



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: ХААИС, ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: САНХҮҮ

Индекс: D041201

Шинжээчийн баг:

Ахлагч:

Б.Энхтуяа (*Шинжлэх Ухаан Технологийн их сургууль, Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн доктор, профессор*)

Гишүүд:

Г.Билгээ (*Мандах их сургуулийн зөвлөх профессор, доктор, дэд профессор*)

Л.Гүнжаргал (*ОУУБИС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, доктор*)

2023.05.04-.05

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ЭЗБС	Эдийн засаг бизнесийн сургууль
ACBSP	Accreditation Council for Business Schools and Programs
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
НББ	Нягтлан бодох бүртгэл
МУИС	Монгол Улсын их сургууль
СЭЗИС	Санхүү эдийн засгийн их сургууль
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АНУ	Америкийн нэгдсэн улс
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ОУМИ	Олон улсын магадлан итгэмжлэл
ТББ	Төрийн бус байгууллага

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Хөдөө аж ахуйн их сургууль, Mongolian University Life Science	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Санхүү, Finance	
Индекс	D041201	
Шинжээчид	<p>Ахлагч:</p> <ul style="list-style-type: none"> Б.Энхтуяа (Шинжлэх Ухаан Технологийн их сургууль, Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн профессор, доктор) <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> Г.Билгээ (Мандах их сургуулийн зөвлөх профессор, доктор, дэд профессор) Л.Гүнжаргал (ОУУБИС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, доктор) 	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа – Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2023.05.04	Сургуулийн орчинтой танилцах
		Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
		Оюутнуудын төлөөлөлтэй уулзах
		Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
	2023.05.05	Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
		Багш нартай уулзах
		Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.		
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ХААИС-д санхүүгийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн түүхэн туршлага нь ХААДС (тухайн үеийн нэрээр)-д анх 1962 онд Хөдөө аж ахуйн эдийн засгийн тэнхим, 1973 онд Нягтлан бодох бүртгэл, статистикийн тэнхим байгуулагдсантай салшгүй холбоотой. Мөн 1992 оныг хүртэл “БНМАУ-ын санхүүжилт”, “УААА-н төлөвлөлт”, “ХАА-н санхүү, зээл”, “ХАА-н санхүүгийн шинжилгээ”, “Татвар, төрийн санхүү” гэх мэт, 1992-2016 онуудад “Банк мөнгө”, “Банк, санхүүгийн үндэс”, “Санхүүгийн менежмент”, “Корпорацийн санхүү”, “Татвар, төрийн санхүү” гэх мэт хичээлүүд зааж байсан байна. Эдгээр туршлага нь 2013 онд Санхүүгийн тэнхим байгуулах, улмаар Санхүү, банкны хөтөлбөрийг нээж хэрэгжүүлэх үндэс болжээ.

ХААИС, ЭЗБС-ийн Санхүүгийн тэнхим нь 2013 онд байгуулагдсан. Өнөөдрийн байдлаар БШУ-ны сайын 2014 оны А/78 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, 2014 оны А/174 тоо тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага батлах тухай” журмын дагуу “Санхүү” хөтөлбөрийг 2017 онд шинэчлэн боловсруулсан.

Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж нь ХААИС, ЭЗБС, Санхүүгийн тэнхим.

Хөтөлбөрийн нэр “Санхүү”,

Хөтөлбөрийн индекс - D041201,

Боловсролын түвшин – Бакалавр,

Хөтөлбөрийн мэргэших чиглэл нь “Санхүүгийн менежер”,

Хэрэгжүүлэх хэлбэр, хугацаа - Өдөр, 4 жил,

Нийт 127 кредит үүнээс Боловсролын суурь хичээл 34 кредит, Мэргэжлийн суурь хичээл 33 кредит (үүнээс сонгон 3 кредит), Мэргэшүүлэх хичээл 60 кредит (үүнээс сонгон 12 кредит) байна. Төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны системд холбогдсон 3436,6 мкв талбай бүхий сургалтын зориулалттай хичээлийн байртай, 5 лабораторитой.

Тус хөтөлбөрөөр 2022-2023 оны хичээлийн жилд нийт 163 оюутан суралцаж байна. Санхүүгийн менежер мэргэжлээр 2018-2022 онд 5 удаагийн төгсөлтөөр нийт 223 оюутан төгссөн ба ажил эрхлэлт 78,3 хувьтай байна.

2022-2023 хичээлийн жилд 11 багш, үүнээс доктор зэрэгтэй 5 (45%) ажиллаж байна. Багшилсан дундаж жил 15 жил. Багш нар 1312 хэвлэлийн хуудас бүхий 32 сурах бичиг, 53 гарын авлага, дотоодод хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл 59, гадаад 18 үүнээс IF индекстэй сэтгүүлд 3 бүтээл тус тус хэвлүүлсэн байна.

2014 онд ХААИС, ЭЗБС-ийн 7 хөтөлбөр АНУ-д төвтэй Бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллага(ACBSP)-аар магадлан итгэмжлэгдсэн. Олон улсын хөндлөнгийн үнэлгээний байгууллага “Перегрэн Академи”-аар элсэгч болон төгсөгчдийн (санхүүгийн хөтөлбөр ороод) мэдлэг ур чадварыг үнэлүүлж байна.

Санхүү хөтөлбөр БМИҮЗ-ийн дотоодын магадлан итгэмжлэлд анх удаагаа энэ онд орж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Санхүүгийн болон даатгалын салбарын эрэлт хэрэгцээг тодорхойлсон. (*Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа 2021*)
- Аж үйлдвэрийн IV хувьсалын нөлөөллөөр ирээдүйд хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээ нь буурах магадлалтай мэргэжлүүд нэмэгдэж байгааг дурдсан. (*Bureau of Labor statistics, US Department of labor, Occupational outlook Handbook, Financial managers*)
- 2025 он хүртэлх ажилтанд тавигдах шилдэг 15 ур чадварыг тодорхойлсон. (*World Economic Forum, Future of jobs report, 2020*)
- Санхүү 1-р курс 30 оюутан, санхүү 2-р курс 37, санхүү 3-р курс 66, санхүү 4-р курс 30 оюутан, нийт **163** оюутан “Санхүү” хөтөлбөрт идэвхтэй сурч байна. Санхүү эчнээ ангид одоогоор элсэлтгүй байна. (*Хөтөлбөрийн танилцуулга мэдээ*)
- 2018-2022 онд нийт 5 удаагийн төгсөлтөөр **223** оюутан Санхүү хөтөлбөрөөр төгссөн. Үүнээс **170** төгсөгч ажил эрхлэлтийн судалгаанд хамрагдсан. Нийт санхүү мэргэжлээр төгсөгчдийн 104 нь банк, ББСБ-д, 9 нь төрийн болон төсвийн байгууллагад, 29 нь хувийн байгууллагад, 26 нь гадаад улсад сурч амьдарч байна. 4 төгсөгч нь бусад хэлбэрээр суралцаж байна. (*Төгсөгчдийн судалгааны үр дүнгээс харах*)
- ХААИС 2019-2028 оны стратеги төлөвлөгөө хэрэгжиж байна, ЭЗБС-ийн стратеги төлөвлөгөөг ХААИС-ийн стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн шинээр боловсруулж байна.
- ХААИС нь хөдөө аж ахуйн салбарт санхүү, эдийн засаг НББ-ийн чиглэлээр 60 шахам жил сургалт явуулж мэргэжилтэн бэлтгэсэн арвин туршлагатай, материаллаг бааз, боловсон хүчний нөөцтэй. (*Албан бичиг*)
- Сургалтын төлөвлөгөөг харьцуулсан МУИС, СЭЗИС-ийн сургалтын төлөвлөгөөний илрэл нотолгоо хангалтгүй.
- Сургалтын төлөвлөгөөг харьцуулсан гадаадын буюу АНУ-ын 6 их сургуулийн сургалтын төлөвлөгөө илрэл нотолгоо хангалтгүй.
- Санхүү хөтөлбөрийг нээхтэй хамааралтай оролцогч талын судалгааны илрэл нотолгоо хангалтгүй. (*Төгсөгчдийн зүгээс тэнхимийн багш нартай ирж уулзаж, хөрөнгө оруулалт IPO-той хамааралтай асуудлаар удаа дараа зөвлөгөө авахаар ирж байсан тухай тэнхимийн эрхлэгч бусад багш нар хэлж ярих*)

Онцлог зүйл:

- 2014 онд АНУ-д төвтэй Эдийн засаг, бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллага(ACBSP)-аар магадлан итгэмжлэгдсэн. ЭЗБС 2024 онд 2 дахь удаагаа ОУМИ-д орохоор төлөвлөн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- МУИС, СЭЗИС, ХҮИС зэрэг сургуулиудын сургалтын төлөвлөгөөг харьцуулж судлахдаа сургалтын төлөвлөгөө тус бүрийн онцлог давуу талыг тодорхойлж дүгнээгүй.
- АНУ-ын 6 их сургуулийн сургалтын төлөвлөгөөг харьцуулж судлахдаа мөн онцлог давуу болон ялгаатай байдлыг тодорхойлж дүгнээгүй.

Дүгнэлт:

- ХААИС нь хөдөө аж ахуйн салбарт санхүү, эдийн засаг НББ-ийн чиглэлээр 60 шахам жил сургалт явуулж мэргэжилтэн бэлтгэсэн арвин туршлагатай, материаллаг бааз, нөөц боломжтой. ОУМИ-д 2 дахь удаагаа орохоор бэлтгэл ажил хэдийн эхэлсэн буюу хөндлөнгийн үнэлгээг Прегрени Академаар хийлгэж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлж буй гадаад, дотоодын их сургуулиас ялгарах онцлогоо тодорхойлох.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Зорилгын биелэлтийг санхүүгийн тэнхимийн багш нарын хурлаар хэлэлцсэн. ХААИС, ЭЗБС, Санхүүгийн тэнхимийн хурлын протокол “Хөтөлбөрийн зорилго хэлэлцэх” 2015.01.16 болон ХААИС, ЭЗБС, Санхүүгийн тэнхимийн хурлын протокол “Хөтөлбөрийн зорилгод өөрчлөлт оруулах, түүнийг хэлэлцэх” 2015.03.20 ба 2022.12.20-ны хурлын протоколд туссан
- Зорилгын биелэлтийг хэдэн хувиар хангаж чадсан, чадаагүй эсэхийг хөтөлбөрийн хорооны хурлаар хэлэлцэхээр хүлээж байгаа. Энэ талаар өөрийн үнэлгээний тайлангийн 21 хуудас, хүснэгт 16-д дэлгэрэнгүй оруулсан.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг ЭЗБС, ХААИС-ийн зорилго, зорилготой уялдуулж тодорхойлсон.
- Зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүнг хэлэлцдэг.

Анхаарах асуудал:

- Зорилго, зорилтыг мэргэшлийн хүрээ, холбогдох мэргэжлийн салбар, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн тодорхойлсон байдал хангалтгүй.
- Суралцагчдад ХАНДЛАГА олгох байдал хөтөлбөрт огт байхгүй.
- Төгсөгчийн загварыг тодорхойлсон байдал сул, хөтөлбөрийн зорилго, хүрэх дүнд үл нийцэхээр загвараа тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилго, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн байдал сургуулийн вэб хуудсанд байршаагүй.

Дүгнэлт:

- ХААИС, ЭЗБС-ийн зорилго, зорилттой уялдуулж хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон. Хөтөлбөрийн зорилгоо ямар мэдлэг, чадвар хангасан мэргэжилтэн бэлтгэх гэж байгаа талаас тодорхойлсон. Хөтөлбөрийн үндсэн зорилтуудад ямар суурь мэдлэг, ямар ур чадвар олгох эзэмшүүлэх талаар тусгасан хэдий ч хандлага олгох байдлыг огт тусгаагүй. Мэргэжлийн мэдлэг, ур чадварыг суралцахуйн үр дүн талаас тусгасан. Зорилгын биелэлтийг санхүүгийн тэнхимийн багш нарын хурлаар хэлэлцдэг.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчийн загварын боловсруулалтыг сайжруулах.
- Хөтөлбөрийн зорилгыг холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхэд анхаарах.
- Мэргэжлийн хатуу ба зөөлөн ур чадвар, хандлага, мэргэжлийн ёс зүйг олгох байдлыг тодорхой оруулах.

Шаардлага:

- Хөтөлбөрийн зорилгыг холбогдох мэргэжлийн салбар, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БШУСайдын А/174-ийн дагуу “Санхүү” хөтөлбөрийг боловсруулж баталсан. Санхүү, банк, D041201, 2017.08.25 А/183
- Нэгж хичээлийн стандартыг 2017.05.10-ны өдрийн хөтөлбөрийн хорооны хурлаар баталсан.
- Сургалтын арга зүйн асуудал Сургалтын бодлого, зохицуулалтын газраас гаргасан “Хичээлээр эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх зөвлөмж” ногоон ном 2016 онд хэвлэгдсэн.
- Мөн Сургалтын бодлого зохицуулалтын алба “Хөтөлбөрийн шинэчлэл хамтын ажиллагааны зөвлөмж” ногоон ном 2016 онд хэвлэгдсэн.
- Оролцогч сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байдлын талаар илрэл нотолгоо хангалтгүй.

Анхаарах асуудал:

- Оролцогч сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусгасан байдал тодорхойгүй

Дүгнэлт:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй,

сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг багтааж “Санхүү” хөтөлбөр, нэгж хичээлийн стандартыг боловсруулж баталсан.

- Нэгж хичээлийн стандартдаа идэвхтэй сургалтын арга, үнэлгээний аргуудыг тусгасан байна.
- Санхүү хөтөлбөрийн зорилго, зорилтыг хангахуйц мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл сургалтын төлөвлөгөөнд байгаа хэдий ч хангалттай бус.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оролцогч сонирхогч талуудын санал зөвлөмжид тулгуурлан хөтөлбөрийг тогтмол сайжруулах байдлыг эрэлхийлэх.

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Ерөнхий эрдмийн хичээл тус бүр индекстэй, математик, англи хэлний хичээлүүд өмнөх холбоотой. Мэргэжлийн суурь хичээл тус бүр индекстэй 200-р эхэлсэн, Макро эдийн засаг, Эдийн засгийн шугаман загвар, Статистик, Зардал удирдлагын бүртгэл, Хөдөө аж ахуйн эдийн засаг хичээлүүд өмнөх холбоотой, бусад хичээлүүд өмнөх холбоогүй. Мэргэжлийн суурь хичээлд Зардал, удирдлагын бүртгэл, Хөдөө аж ахуйн эдийн засаг хичээлүүд 300 кодтой. Мэргэшүүлэх хичээл тус бүр индекстэй 301 кодоор эхэлсэн. Мэргэшүүлэх бүх хичээл 3 кр, өмнөх холбоотой. Сургалтын дадлага 2 кр, Үйлдвэрлэлийн дадлага 3 кр, Төгсөлтийн ажил 1 кр.
- Нийт 127 кр. Үүнээс Ерөнхий эрдэм-34 кр, Мэргэжлийн суурь заавал хичээл 30к кр, сонгон судлах хичээл 3 кр, Мэргэшүүлэх заавал хичээл 48 кр, сонгон судлах хичээл 12 кр буюу заавал судлах 112 кр, сонгон судлах 15 кредитээс бүрдэж байна. Ерөнхий эрдэм хичээл 26.7%, мэргэжлийн суурь хичээл 25.9%, мэргэшүүлэх хичээл 47.2% байхаар хуваарилагдсан.
- Сургалт удирдлагын мэдээллийн системтэй . Үүнд: 2015-2020 онд ULMS систем, 2020 оноос одоог хүртэл ISLS системийг ашиглаж байна. www.student.muls.edu.mn вэбээр нэвтэрч хичээл сонголт, хуваарь төлөвлөлт, цахим сургалт, сурлагын үнэлгээ, амжилт чанарыг харах боломжтой.
- Улирал дуусахад нэгж хичээл тус бүрээр сэтгэл ханамжийн судалгааг авдаг. Сургалтын төлөвлөгөөнд нэгдсэн шинжилгээ, илрэл нотолгоо хангалтгүй.
- Санхүү хөтөлбөрт сургалтын дадлага 2 кр, үйлдвэрлэлийн дадлага 3 кр. Сургалтын дадлагыг оюутан 3 курсдээ, үйлдвэрлэлийн дадлагыг 4 курсдээ хийхээр төлөвлөсөн.

- 2022-223 оны хичээлийн жилд үйлдвэрлэлийн дадлагад 33 оюутан банк, даатгал, чингэлтэй дүүргийн татвар, ХК, ХХК-ийн санхүүгийн албанд гарсан байна.
- Үйлдвэрлэлийн дадлагыг явцын үнэлгээ 1,2 гэж ангилан үнэлж байна. Явцын-1 үнэлгээ нийт үнэлгээний 50 хувь, явцын-2 үнэлгээ 50 хувь байхаар удирдамжид тусгасан. Явцын 1 үнэлгээ нь удирдамжийн дагуу гүйцэтгэсэн байдал, явцын 2 үнэлгээ хамгаалалтын үнэлгээнээс бүрдэж байна. Дадлагын удирдамжийг хэлэлцэж баталдаг.(2021 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн Санхүү тэнхимийн хурлаар хэлэлцэн баталжээ.)
- Сургалтын дадлагын үнэлгээ 3 бүрэлдэхүүнтэй. Санхүү, даатгал, төрийн санхүүгийн хүрээнд өгөгдсөн нэг кейс ажиллана, лабороторид гүйцэтгэлийг тооцоолоод удирдсан багшаар үнэлүүлнэ. Арга зүйн үнэлгээ тэнхимээс судалгааны сэдэв өгөөд оюутнууд тухайн сэдвийн дагуу удирдагч багштай болоод судалгааны арга зүйг ашиглан судалгаа хийн хамгаална, эцэст нь тодорхой нэг байгууллага дээр 7 хоногийн хугацаатай дадлагад гараад тайлан бичин хамгаалдаг.
- Ковидын нөхцөлд сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагыг 2021.03.21-ны Санхүүгийн тэнхимийн багш нарын хурлаар удирдамжуудыг өөрчилсөн. Үүнд хөрөнгийн биржийн сайтад бүртгэлтэй нээлттэй ХК-ийн санхүүгийн мэдээлэл дээр ажилласан.
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан ХӨТӨЛБӨРИЙН МОД-той. Хөтөлбөрийн модыг сургалтын төлөвлөгөөний өмнөх холбоотой уялдуулж хийсэн байдлыг харахад хангалтгүй. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн модноос САНХҮҮ хөтөлбөрөөр суралцагчийн гол цөм хичээл тодорхойгүй.
- Санал болгох төлөвлөгөөг боловсруулсан. 2022-2023 оны хичээлийн жилээс уртаар хичээллэх системд шилжсэн. 1-р курсын оюутнууд уртаар хичээллэх системээр, 2,3,4-р курсын оюутнууд богиноор хичээллэх системээр хичээллэж байна. (Уртаар хичээллэх системийг түр журмаар зохицуулсан, албан ёсоор журам энэ хичээлийн жилдээ багтаан батлахаар хүлээж байна. Богиноор хичээллэж буй сургалтын журмыг Захирлын 2016.7,28 А/153,)
- Сургалтын ачааллыг тооцохдоо 3 кредит хичээлийн хувьд лекц 32 цаг, семинар 32 цаг, бие даалт 80 цаг. Ерөнхий суурь хичээлийн хувд нийт академик цаг 1632, үүнээс лекц 368 цаг буюу 22,5%, семинар 352 цагт буюу 21.6%, бие даалт 912 цаг буюу 56.9%, Мэргэжлийн суурь хичээлийн хувьд нийт 1440 цаг, лекц 320 цаг буюу 22.2%, семинар 320 цаг буюу 22,2%, бие даалт 800 цаг буюу 55,6%, Мэргэшүүлэх хичээлийн хувьд нийт 3024 цаг үүнээс лекц 601 цаг буюу 20,1%, семинарын цаг 608 буюу 20,1%, бие даалт 1520 цаг буюу 50,3% байхаар тооцоолсон. Суралцагчийн цагийн ачааллыг улирал тус бүрээр тооцож гаргасан.

Онцлог зүйл:

- Сургалтын дадлагыг онол практик хослуулах, мөн оюутныг бүтээлч байдалд сургахад дэм болохоор сургалтыг зохион байгуулж байна. Сургалтын дадлага нь Кейс бодлого ажиллах, Судалгаа хийх, Практик байгууллагад биечилж дадлага хийх гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэж байна.
- Хичээлийн агуулга, давхардал, тэдгээртэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийн багш нараас бүрдсэн секцүүд бий болон ажиллаж эхэлсэн сайн жишээ харагдав.

Анхаарах асуудал:

- Дадлагын тайлангуудыг архивлаж хадгалдаггүй.

- Суралцагч хичээлийг сонгон судлах байдал хязгаарлагдмал. 2017 оны сургалтын төлөвлөгөөнд сонгон судлах хичээл багассан.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварыг сургалтын төлөвлөгөөн дэх нэгж хичээлээр олгох байдал хязгаарлагдмал. Жишээлбэл “Санхүүгийн менежмент I” хичээл 3.2.1 “Бизнесийн орчинд үнэлэлт өгөх удирдан зохион байгуулахтай холбоотойгоор эрэлт, борлуулалт үнийг таамаглах” гэсэн мэргэшүүлэх ур чадварыг олгож байна. Тус хичээл бусад өөр хамааралтай мэдлэг, чадвар өгөхгүй байхаар хуваарилсан. “Хувь хүний санхүү” хичээл тухайн хөтөлбөрт ямар ч мэдлэг, чадвар, хандлага олгогдохоор тавигдаагүй байна.
- Санхүүгийн тэнхимд дадлага хийхтэй холбоотой байгууллагуудын гэрээ, санамж бичиг одоогоор байхгүй.
- Хичээлийн мод, залгамж холбоо ойлгомжгүй боловсруулсан.
- Санхүү хөтөлбөрийн цөм хичээл тодорхой бус.

Дүгнэлт:

- Сургалтын төлөвлөгөөнд буй хичээлүүд индекс, үр дүнгийн матрицтай холбосон, санал болгох төлөвлөгөөтэй. Хичээлийн залгамж холбоог харуулсан мод ойлгомжгүй боловсруулсан.
- Хичээлийн агуулга, давхардал, тэдгээртэй хамааралтай асуудлыг шийдвэрлэх, хичээлийн агуулга сайжруулалтай холбоотой мэргэжлийн багш нараас бүрдсэн секцүүд бий болон ажиллаж эхэлсэн.
- Сургалтын дадлага 2 кр нь оюутны бүтээлч байдал, практик чадвар олгох байдлаар явуулдаг.
- Сургалтын төлөвлөгөөнд оюутны хичээл сонгон судлах боломж хязгаарлагдмал.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг эргэн харж, сайжруулах.
- Сургалтын дадлага, үйлдвэрлэлийн дадлагын удирдамжийг Төрийн санхүү, Банк-даатгал, Бизнесийн байгууллага гэсэн 3 хүрээнд мэргэшүүлж агуулгыг нарийвчилж илүү сайжруулах. Жишээ нь, Банкинд дадлага хийх оюутан банк санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлан, шинжилгээ, бүртэлийн үйл ажиллагаа бусад холбогдох зүйлийг, бизнесийн байгууллагад дадлага хийх оюутан ХК, ХХК-ийн санхүү, бизнесийн үйл ажиллагааг судалж дүгнэх, төрийн байгууллагад дадлага хийх оюутан төрийн санхүүгийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт хийгдэх шинжилгээний аргачлалын хүрээнд судалж тайлангаа бичиж хамгаалбал оюутанд илүү ойлгомжтой, тухайн салбар бизнесийн онцлогоо илүү судлахаар харагдаж байна.
- Сургалтын төлөвлөгөөнд оюутны хичээл сонгон судлах боломжийг нэмэгдүүлэх.
- Санхүү сургалтын төлөвлөгөөндөө шинжилгээ хийж дүгнэх.

Шаардлага:

- Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүд нь хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг хэрхэн олгох байдлыг дахин сайжруулах.
- Хөтөлбөрийн модыг ойлгомжтой боловсруулж, цөм хичээлийг тодорхойлох.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлээр эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх зөвлөмж, Хөтөлбөрийн шинэчлэл хамтын ажиллагааны зөвлөмжийг 2016 онд хэвлэсэн. Сургалтын бодлого, зохицуулалтын газар *(ногоон ном)*
- Үр дүнд суурилсан бакалаврын хөтөлбөр боловсруулах зөвлөмж, 2023, сургалт цахим шилжилтийн бодлогын газар(төсөл) мэргэжлийн хөтөлбөр сайжруулж байна.
- ХААИС, ЭЗБС-ийн захирлын 2022.04.22-ны өдөр А/41 “Заах арга зүйн зөвлөлийг батлах тухай” тушаал гарч үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 2022.09.16 Заах арга зүйн зөвлөл хуралдаж, зөвлөлийн нарийн бичгийн дарга болон ажлын төлөвлөгөөг хэлэлцэж баталсан. 2022-2023 оны хичээлийн жилийн хүрээнд ЭЗБС-ийн хэмжээнд хийгдэх ажлыг төлөвлөж батлуулсан. Зарим хийгдсэн ажлыг анализ хийж дүгнээгүй байна. Тус зөвлөл нийт 2 удаа хуралджээ. 2023.01.02-нд ХААИС, ЭЗБС-ийн захирлын А/02 тоот тушаал “Төсөв батлах тухай” тушаал баталж 2022-2023 оны хичээлийн жилд идэвхтэй сургалтын арга судалгааны үр дүнд тулгуурлан сургалт, заах арга зүйн семинарыг 20223 оны 1 дүгээр сарын 04 өдөр зохион байгуулсан.
- Хичээлийг хөндлөнгөөс үнэлсэн үнэлгээний тайланг Сургалтын алба 2018, 2019 онд авч дүгнэсэн. Мөн ACBSP Прегрен Академаар хөндлөнгийн үнэлгээг 2016 оноос одоог хүртэл үнэлүүлж байна. Жишээлбэл 2016-2021 оны дунджаар Санхүү хөтөлбөрөөр суралцагч оюутны мэдлэг 31.9-39.0% болж өссөн.
- Хичээл зааж буй багш тус бүрийн хувийн материалд тестийн сан үүссэн. Файл хэлбэрээр багш бүрт байдаг.
- “Бакалаврын сургалтын журам”-ын ес-д “Төгсөлтийн шалгалтын үйл ажиллагаа”-г зохицуулсан.

Онцлог зүйл:

- “Сургалт заах арга зүйн зөвлөл” ажиллаж эхэлсэн. Тухайн зөвлөл нь багшийн хичээлд сууж заах арга зүйн зөвлөгөө өгөх, Заах арга зүй сайтай, туршлагатай багш нараар нээлттэй хичээл заалгах, туршлага солилцох, Багш нарын заах арга зүйг сайжруулах, бүтээлч ажлуудыг санаачлан хэрэгжүүлж туслах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.
- Хичээл тус бүр хичээлийн эхлэл болон төгсгөлд оюутны мэдлэг, чадвар, хандлагыг хөндлөнгөөс үнэлдэг. ACBSP, Перегрэн Академи 2016 оноос одоог хүртэл үнэлж байна.
- Зөвхөн хавар төгсөлт хийдэг.

Анхаарах асуудал:

- Мэргэшүүлэх хичээлүүдийг төрөлжүүлэх. Сургалтад сургалтын шинэ технологи нэвтрүүлэхэд анхаарах.
- Төгсөлтийн ажил, улсын шалгалтыг ямар шалгуур хангасан оюутан өгөх нь тодорхойгүй.

Дүгнэлт:

- Зөвхөн хаврын төгсөлт хийдэг. Төгсөлтийн журамд улсын шалгалт, төгсөлтийн ажил гэсэн хэлбэртэй. Төгсөлтийн журамд улсын шалгалт, төгсөлтийн ажлыг ямар нөхцөлд хийхийг тодорхой заагаагүй.
- Санхүүгийн менежмент I, Хөрөнгө оруулалтын менежмент, Төрийн санхүү II, Санхүүгийн мэдээллийн систем хичээлүүдийн стандарт 2017 онд баталж, тамгалсан. Бусад хичээлийн стандартууд огт батлагдаагүй буюу тамгагүй байв. *(Багшийн хичээлийн хавтас бүрээс харав)*
- Банк санхүүгийн салбарт ажиллах зорилтод зөвхөн Банкны менежмент 3 кр, Даатгалын салбарт Даатгалын менежмент 3 кр, Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын менежмент 3 кр, санхүүгийн зах зээл 3 кр хичээлүүдээр хязгаарлагдсан байгаа нь учир дутагдалтай байна.
- Нэгж хичээлийн хавтсанд сургалтын шинэ технологи, арга хэрэгсэл нэвтрүүлсэн туршлага хомс.
- Гадаад хэлний хичээл: Англи хэл I, II хичээл нийт 4 кредит байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хичээлүүдийг илүү төрөлжүүлэх, банк болон даатгалын нэг хичээлээр хязгаарлахгүй байх.
- Төгсөлтийн ажил, улсын шалгалтыг ямар болзол хангасан оюутан өгөх нь тодорхойгүй. Үүнийг төгсөлтийн журам эсвэл Санхүүгийн тэнхимийн хөтөлбөрийн хорооны хурлаар тухайн хичээлийн жилд зохицуулж тодорхой болгох.
- Шинэ технологи нэвтрүүлэх. Жишээлбэл, улиралд эсвэл хичээлийн жилд аль нэг мэргэшүүлэх хичээлийг англи хэл дээр орж турших.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Захирлын 2016.07.28 А/153 тоот тушаалаар “Бакалаврын сургалтын журам”-ын зургаад “Оюутны мэдлэг чадвар хандлагыг үнэлэх стандарт, стандарт бус үнэлгээгээр үнэлнэ” гэж тодорхой тусгасан. Стандарт үнэлгээ нь А А-, В+ В В-, С+ С С-, D+ D D-, F, Стандарт бус үнэлгээ нь R, W S U байна.
- Мэргэшүүлэх хичээлийн хувьд хичээлийн сэдвүүдийг даалгавар, кейс ажиллагаа, хаалттай шалгалтын аргуудаар үнэлэхээр тусгасан. Мэдлэг, чадвар, хандлагыг гүйцэтгэл, Рүбрик аргуудаар үнэлэхээр стандартад тусгасан. Мөн явцын үнэлгээ 70, эцсийн үнэлгээ 30 байхаар зохицуулсан. */нэгж хичээлийн хавтас/*
- Мэргэжлийн суурь хичээлийн лекц, семинарын сэдвүүдийг ерөнхий асуулт тавих, хэлэлцүүлэг, илэрхийлэх ажиллагаа аргуудаар, мэдлэг чадвар хандлагыг гүйцэтгэл, рубрикийн аргаар үнэлэхээр тусгасан.

Онцлог зүйл:

- Суралцагчийн үнэлгээг нээлттэй ил тод зарчмаар тооцдог.
- Амжилт, чанарын судалгааг хийдэг

Дүгнэлт:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, сайжруулалт хийгдсэн.
- Мэргэшүүлэх хичээлийн сэдвүүдийг даалгавар, кейс ажиллагаа, хаалттай шалгалтын аргуудаар, мэдлэг, чадвар, хандлагыг гүйцэтгэл, Рүбрик аргуудаар үнэлдэг. Мөн явцын үнэлгээ 70, эцсийн үнэлгээ 30 байхаар зохицуулсан.
- Мэргэжлийн суурь хичээлийн лекц, семинарын сэдвүүдийг ерөнхий асуулт тавих, хэлэлцүүлэг, илэрхийлэх ажиллагаа аргуудаар, мэдлэг чадвар хандлагыг гүйцэтгэл, рүбрикийн аргаар үнэлдэг.
- Мэргэжлийн хөтөлбөрийн сайжруулалттай холбоотойгоор нэгж хичээлийн стандарт, үнэлгээний арга томъёоллыг өөрчлөн сайжруулж байна. /2022-2023 оны хичээлийн жилд багтаж сайжруулж дуусахаар төлөвлөсөн/

Үнэлгээ: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо (хуудас 65-66)

- “Олон нийт, иргэний барилга БНБД31-03-03”д заасан байр, талбайн хэмжээ, эрүүл ахуйн норматив” хангасан байдал.
- Сургуулийн барилгын өрөө, тасалгааны байршил, талбайн хэмжээтэй зураг. ЭЗБС нь төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны системд холбогдсон 3436,6 кв талбай бүхий сургалтын зориулалттай стандартын хичээлийн байранд шаардлагатай урсгал засвар, тохижилт хийж сайжруулан сургалт, ЭШ судалгааны ажил явуулж байна. Үүний 74,5% нь сургалтын зориулалтаар ашиглагддаг. Сургууль авто машины зогсоолтой. Гадаад орчин ногоон байгууламж, гэрэлтүүлэг, тав тухтай бөгөөд эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагын дагуу мэргэжлийн хяналтын байгууллагуудтай чиглэл бүрээр хамтран ажиллаж байгаа байдалтай биечлэн танилцав.
- Анги танхим, лабораториуд танхимын болон цахим сургалт явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, байнга сайжруулж шинэчилж иржээ. Сургалтад ашиглах 5 лабораторитой.
- “Цахим сургалтын төв” байгуулан (215 тоот) ашиглаж байна. (хүс 3-2)
- Багш нарт компьютер, олон үйлдэлт хэвлэх, хувилах техник хэрэгсэлээр хангагдсан ажиллах орчинг бүрдүүлсэн.
- Багшийн амралтын өрөөг тохижуулж эхэлсэн.
- Галын аюулгүй байдал, хэрэглээний усны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэдэг.

- Хичээлийн байранд ундны усны машин, савласан ундаа жүүсний машин ашигладаг.

Онцлог зүйл:

- ЭЗБС-ийн төсөв, санхүүжилт нь ХААИС-ийн санхүүгийн үйл ажиллагааны зохион байгуулалтаас шалтгаалан нэгдсэн журмаар зохицуулагддаг.
- ХААИС-ийн удирдлагын зохион байгуулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулах асуудал эхэлсэн.
- ЭЗБС-ийн баклавын сургалтын төлбөрийн орлого нь ХААИС-ийн үндсэн үйл ажиллагааны орлогын 50 орчим хувийг бүрдүүлж байна.
- Сургалтын орчны талаарх оюутны сэтгэл ханамжийн үнэлгээний дундаж нь ХААИС-ийн дундаж үзүүлэлтээс дээгүүр
- Номын сангийн суудлын хүртээмж стандарт үзүүлэлт 15-с доогуур 0,09 байсныг номын сангийн шинэ байр ашиглалтад оруулснаар амжилттай шийдвэрлэх боломж бүрджээ.

Анхаарах асуудал.

- Лабораторийн нэг суудалд ногдох талбай стандартаас 34,8%, лекцийн нэг суудалд ногдох талбай стандартаас 54% доогуур.
- Хичээлийн байранд цайны газрын түрээслэгчийг сонгоогүйн улмаас сүүлийн жилүүдэд ажиллаагүй.

Дүгнэлт:

- Сургалтын барилга байгууламж, түүний орчин нь нийт талбайн хэмжээ, эрүүл ахуйн нормативд нийцэж дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах стандарт шаардлагын 3-11 үзүүлэлтүүд стандартыг бүрэн хангасан.
- Оюутнууд намрын улирлаас хаврын улирлын эхний хагас хүртэлх хугацаанд хичээлийн бус цагаар бие даан болон багаар ажиллах анги танхим дутмаг гэсэн асуудлыг:
 - номын сангийн хуучин өрөөг тохижуулан ашиглах,
 - номын сангийн шинэ байрны зохион байгуулалтад оруулж зохицуулахаар болсон байна.
- Харин сургалтын орчны стандартаас доогуур байгаа зарим үзүүлэлт нь оюутны тооноос хамааралтай, гэхдээ шаардлагын түвшинд хүргэх асуудлыг төлөвлөгөө, төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой талаар сургуулийн захирал танилцуулсан. Тухайлбал, цайны газрын зэрэгцээ зориулалтын өрөө, тоног төхөөрөмж нь бэлэн байгаа тул түрээслэгчийг сонгож, гэрээгээр ажиллуулах ажил хүлээгдэж байна.
- Сургалтын орчны стандартыг хангасан байдал, анхаарвал зохих зарим үзүүлэлтүүдийг засаж сайжруулах боломжтой гэж үзлээ.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Кофе, хөнгөн зуушаар үйлчлэх боломжийг бүрдүүлэх
- Сургалтын орчны стандартаас доогуур байгаа дээр дурдсан үзүүлэлтийг шаардлагын түвшинд хүргэх асуудлыг төлөвлөгөө, төсөвт тусгаж хэрэгжүүлэх

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Шалгуур үзүүлэлтийн дагуу бэлдсэн тайлан мэдээллийг судлахын зэрэгцээ биечлэн танилцаж, багш, оюутнуудтай ярилцав.

- Лекцийн танхим, лабораторуудыг цахим орчинд тохируулан тоноглогсон.
- Хичээлийн болон оюутны байранд утасгүй интернет ашиглаж байна.
- Хөтөлбөрийн онцлогоос хамааран лабораторуудыг сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж шаардлагатай сургалт, судалгааны програм хангамжаар хангадаг.
- Оюутнууд ажлын өдөр, хичээлийн бус цагаар лабораторт бие даан ажиллах боломжтой.
- Цахим хичээлийн хөтөлбөр, багцыг бүрдүүлсэн байв.
- Европын холбооны ERASMUS PLUS байгууллагын санхүүжилттэй “Хүнс ХАА салбарын цахим сургалтыг дэмжих” төсөлтэй хамтран 2019-2020 оны хичээлийн жилийн IV,V улирал, 2020-2021 оны хичээлийн жилийн II улиралд явуулсан лекц, семинар, бие даалтын цахим сургалтын чанарын талаар оюутнуудаас авсан судалгааны ерөнхий үнэлгээ 70,8-73,0 байв.(доктор Г.Ганзориг, Судалгааны товч тайлан)
- 2018 оноос хойш лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөв хуваарилагдаагүй.

Анхаарах асуудал:

- Оюутан, төгсөгч, ажил олгогч нартай уулзах үеэр, хэрэглээний (ялангуяа Excel) програм ашиглах чадвар дутмаг, санхүүгийн мэргэшлийн практикт өргөн ашиглагддаг програмуудыг сургалтад чөлөөтэй ашиглах боломжийг нэмэгдүүлэх санал хүсэлт нэлээд давхацсаныг дурдах нь зүйтэй.
- Сургалтын орчны талаар авсан судалгааны үр дүн, оролцогч талуудын саналыг ажил хэрэг болгох асуудал хангалтгүй.

Онцлог зүйл:

- НҮБ-ийн ХХААБ-аас боловсруулсан Рурал Инвест багцыг Монгол нутагшуулан сургалт зохион байгуулах албан ёсны эрхийн дагуу 3 гарын авлага, 9 хичээл, програм хангамжийг хөтөлбөрийн хичээлд ашиглаж байна.
- Удирдлагын мэдээллийн нэгдсэн системийн програм бүрэн ажиллаж хэвшээгүй.
- ХААИС-ийн хэмжээнд менежментийн багийн шинэчлэл үргэлжилж байна.
- Санхүүгийн үйл ажиллагааны мөрдөж байгаа журмыг шинэчлэхэд шаардлагатай төсвийн хуваарилалт төдийгүй нэгж бүтээгдэхүүн, үйл ажиллагааны нэгжийн өртөгийн үндэслэл, арга зүйг шинэчлэх санал ЭЗБС-ийн багш нар боловсруулж ХААИС-д өгсөн.

Дүгнэлт:

- ЭЗБС-ийн сургалтын орчин, материаллаг баазын талаар оюутны сэтгэл ханамж нь ХААИС-ийн дундажаас дээгүүр байна. Цахим сургалтын чанарын судалгааны ерөнхий үнэлгээг дээшлүүлэхтэй холбоотой ажлыг системтэйгээр хэрэгжүүлэх хэрэгцээ байна.
- Интернетийн хурд, ашиглаж байгаа компьютерийн үзүүлэлт, хөтөлбөрт шаардлагатай мэргэжлийн хичээл сургалт, судалгааны лиценцтэй програм хангамжийн тоог нэмэгдүүлэх асуудлыг тулгамдаж байна.
- Санхүүгийн үйл ажиллагааны мөрдөж байгаа журмыг шинэчлэхэд ЭЗБС-ийн багш нарын оролцоо чухал.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Сонирхогч оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаагаар гарсан саналуудыг хөтөлбөрийн хэрэгжилтэд бодит ажил болгох, үр дүнг хэмждэг болох
- Сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх

Шаардлага:

- Ажил олгогч, төгсөгч, оюутан, багш нарын судалгааны үр дүнг харгалзан хөтөлбөрт зайлшгүй шаардлагатай ур чадвар олгох сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөц түүний санхүүжилтийг төсөв, төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх
- ХААИС нь Сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх зардлын төсвийг нэмэгдүүлэх, шийдвэрлэх

3.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн төв номын сан нь нээлттэй, чөлөөт сонголтын, төрөлжсөн, цахим үйлчилгээний зохион байгуулалтад шилжиж байна.
- Номын сангийн фондын баяжилтын динамик үзүүлэлт (хууд 74-75)
- “Online library management”, нээлттэй эхийн програм “Zorero” ном зүйн мэдээллийн санг бий болгосон.
- Цөөн тоотой, эрэлт ихтэй ном судалгааны ажлуудыг электрон каталогт оруулан цахимаар унших боломжийг бүрдүүлсэн. Баклавын “Төгсөлтийн ажил”, магистрын ЭША, докторын судалгааны ажлуудыг цахим номын санд байршуулсан.
- “Санхүү” хөтөлбөрийн үндсэн сурах бичиг, гарын авлага, ЭШ, цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийг бүрдүүлж эхэлсэн.
- Сургалтын төлбөрийн орлогоос хөтөлбөрт зарцуулах хэмжээг төсөвлөж хэрэгжүүлэх асуудалд тэнхим саналыг тусгаж хэрэгжүүлэх асуудал ХААИС-ийн санхүүгийн журмаар зохицуулагддаг хэдий ч шаардлагын түвшингээс доогуур.
- Оюутнуудын 90% нь номын сангийн карт нээлгэж, 70% нь тогтмол үйлчлүүлдэг.

Онцлог зүйл:

- ХААИС-ийн төв номын сан нь бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд ЭЗБС-ийн номын фондыг төв байранд шилжүүлсэн.
- ЭЗБС-ийн номын сангийн шинэ байрны зохион байгуулалт, ашиглалтын асуудал бүрэн цэгцрээгүй.

Анхаарах асуудал:

- Оюутнууд номын сангийн үйлчилгээний цагийг нэмэгдүүлэх шаардлага тавьсан байхад номын санчийн орон тоог 2 дахин бууруулсан.
- “Санхүү” хөтөлбөрийн мэргэшүүлэх хичээлийн ном сурах бичгийн төрөл, сүүлийн онуудын хэвлэл харьцангуй дутмаг, номын баяжилт хийх төсөв дутагдалтай.

Дүгнэлт:

- Номын сангийн уламжлалт үйлчилгээнээс гадна чөлөөтэй ашиглах орчинг бүрдүүлсэн өрөө, тасалгааг бий болгохыг зорьж байгаа.
- ЭЗБС-ийн номын сангийн шинэ байртай болсон нь номын сантай холбоотой асуудлуудыг эерэгээр шийдэх боломжийг бүрдүүлсэн.
- Гадаадын их дээд сургуулиуд, олон улсын байгууллагууд, салбарын байгууллагуудын хамтын ажиллагаа харилцаанд түшиглэн ахиц гаргах боломжтой.
- Номын фондын баяжилтыг жил бүр хийдэг боловч төсөв бага, мэргэжлийн сүүлийн үеийн ном сурах бичгийн баяжилт хангалттай хэмжээнд хараахан хүрээгүйд дүгнэлт хийж хүлээн авсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Номын сангаар тогтмол үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх.
- Сургалтын орчны талаарх мэдээллийг үйл ажиллагаанд тусгаж, хэрэгжүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор эрхзүйн баримт бичгийг ХААИС-ийн ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2019-2028, 2019; Оюутны хөгжил хөтөлбөр, бодлогын баримт бичиг, 2019; Багшийн хөгжил хөтөлбөр, бодлогын баримт бичиг, 2018; ХААИС, Багшийн гарын авлага, 2017; Санхүү банк мэргэжлийн хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө 2018-2027, 2017; ХААИС-ийн эдийн засгийн судалгааны ажлын дунд хугацааны хөтөлбөр 2018-20252-р тус тус боловсруулсан.

- Хөтөлбөрийн нэгж дэх багш бүрийн ажлын төлөвлөгөөнд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөг боловсруулдаг ба энэ нь Багшийн өөрийн үнэлгээний тайлан, 2018-2021, Санхүүгийн тэнхмийн 2018-2021 оны хичээлийн жилд гүйцэтгэсэн ажлын өөрийн үнэлгээний тайлангийн нэгтгэл, ХААИС, ЭЗБС, Санхүүгийн тэнхмийн хурлын тэмдэглэл, 2015-2022, ЭЗБС-ийн хөтөлбөрийн дэд хорооны хурлын протокол, 2017-4-20, 5-10, 5-20 зэрэгт туссан байна.
- Нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах зорилгоор ХААИС, ЭЗБС-ын захиралын 2018-3-12-ны А/18 тушаал. ЭЗБС-ийн 60 жилийн ойг угтаж хийсэн ажлын хүрээнд ЭЗБС-ийн төгсөгчдийн холбооноос зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн ба Салбарын тэргүүлэх эрдэмтэд, бизнесменүүдтэй хийсэн уулзалтыг 2018-2019 онд 5 удаа зохион байгуулсан. Суралцагч оюутнуудын гаргасан санал гомдол нь гол төлөв оюутны шилжилт хөдөлгөөн, чөлөө, үргэлжлэн суралцахтай холбоотой ба ХААИС, ЭЗБС-с Оюутныг чөлөөлөх, жилийн чөлөө олгох, үргэлжлүүлэн суралцуулах, шилжүүлэх тухай, 2017-2021 онд захиралын тушаал гарсан.
- ХААИС 2020 онд Удирдлагын Мэдээллийн Систем(ISLS)-ийг шинээр боловсруулж, хэрэгжүүлж байна.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичгийг боловсруулж, албажуулсан.
- Хөтөлбөрт ирсэн санал гомдлыг шийдвэрлэдэг механизмтай.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөтэй.
- ХААИС бие даасан ISLS УМС -тэй зэрэг хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байна.
- Удирдлагын багийн шинэчлэл хийгдсэн, үргэлжилж байгаа.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой Эрхзүйн баримт бичгийн, Тайлан төлөвлөгөөний хэрэгжилт, Сургалтын УМС-ийн ашиглалт, хяналт, ил тод байдалд дүн шинжилгээ хийсэн, үр дүнг хөтөлбөрийн төлөвлөлт, удирдлагад хэрхэн хэрэгжүүлж байгааг нотлох баталгаажуулах боломжгүй.
- Санхүү банк мэргэжлийн хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө 2018-2027 нь 2017 онд батлагдсан боловч (3 үе шатаар хэрэгжүүлэх) үр дүнгийн гүйцэтгэл, хэрэгжилт нотлох баримтаар тодорхой бус, ЭЗБС-ийн төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа тогтмол бус, төлөвлөгөө, тайланг нотлох баримтаар харах боломжгүй.

Дүгнэлт:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн орчин бүрдсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөг хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлаар хэлэлцэн, тэмдэглэл тогтмол хөтөлж хэвшсэн. Хөтөлбөрт ирсэн санал гомдлыг ХААИС болон тухайн сургуулийн сургалтын албаас шийдвэрлэдэг. ХААИС бие даасан ISLS УМС-тэй зэрэг нь хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байна. Мөн ХААИС-ийн хэмжээнд 2020-2022 онд хийгдсэн дүрэм журмын шинэчлэл өөрчлөлт хийгдсэн боловч Веб хуудаст тодорхой тусгагдаагүй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Эрхзүйн баримт бичгийн, Тайлан төлөвлөгөөний хэрэгжилт, Сургалтын УМС-ийн ашиглалт, хяналт, ил тод байдалд дүн шинжилгээг тогтмол хийж үр дүнг тайлагнаж хэвших
- Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмын шинэчлэл өөрчлөлтийг өөрийн үнэлгээний тайланд тусгаж байх, оролцогч сонирхогч талуудад мэдээлдэг байх
- Хөтөлбөрийн шинэчлэл, эрэлт хэрэгцээг тодорхойлоход оролцогч сонирхогч талуудадын оролцоог илүү тодорхой болгох, албан болон албан бус санал зөвлөмжийг хөтөлбөрт хэрхэн тусгасан, ямар үр дүн гарч байгаа судлах, мэдээлэх, эргэх холбоог сайжруулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хамтын ажиллагаа нь төсөл, гэрээт ажил, сурах бичиг, аргагүй боловсруулах, багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр (ӨМӨЗО Эрээн хотын Багшийн их сургууль, МҮДуС), сургалт, судалгаа, семинар (ӨМӨЗО-ны Хөх хот) шинжээч зэрэг хэлбэрээр явагддаг.
- Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож ажлын хүрээнд БНХАУ, Өвөр монголын Багшийн их сургуулийн харьяа Эрээн хотын Олон улсын дээд сургууль болон Монгол улсын ХААИС, ЭЗБС хамтран ажиллах гэрээ, Судалгааны ажил гүйцэтгэх гэрээ, НДР-2022/15 CS-20, ХААШУА, ХААИС, ХАА-н эдийн засгийн судалгааны ажлын дунд хугацааны хөтөлбөр 2018-2025, 2017 онд боловсруулж, ММНБИ, ХААИС-ийн Санхүүгийн тэнхим (М.Батхуяг, З.Ядмаа), Ажил гүйцэтгэх гэрээг 2022-9-14-наас 2022-9-25 хугацаанд байгуулж Ахисан түвшний санхүүгийн менежмент сурах бичиг хянан толилуулсан, Захиалгат судалгааны ажлын төсөл, ШуҮз2019/20-ны хүрээнд 2019-2022 онд Монгол улсад суурь тэтгэвэрийг нэвтрүүлэх боломж, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж загвар боловсруулсан, СЯ, ХААИС, ЭЗБСийн багш М.Баттуяг, Төсөв санхүүгийн тогтвортой байдлын төсөлийн хүрээнд төслийн зөвлөхөөр ажиллах гэрээг 2022-10-23-ноос 2023-3-24 хугацаанд байгуулж Санхүүгийн тайланд шинжилгээ хийх аргачилалыг шинэчлэн боловсруулсан.
- Эрдэнэс таван толгой ХК-тай Хөлсөөр ажиллах гэрээг 202-9-28-наас 2 сарын хугацаатай тэнхмийн багш нар байгуулж Компаний санхүүгийн тайланд тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой нөөц өр төлбөрийг НББОУС19 стандартад заасны дагуу бүртгэх, ажилчдын тэтгэвэр тэтгэмжийн бодлого, хэрэгжүүлэх журмыг боловсруулсан. Профессор Д.Далхжав УИХ-ын НББХороо, НДҮЗөвлөлтэй Хөлсөөр ажиллах гэрээ 22/02, Монгол улсын их хурлын байнгын хорооноос Хараат бус шинжээч томилох тухай, 2022-4-12, №08 тогтоол гарган ажилласж байсан.
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалтын хүрээнд 2017-2022 онд БНХАУ, Эрээн хотын Олон улсын сургуулийн 31 оюутан 2+2 хөтөлбөрөөр ирж суралцсан, 11 багш гадаадад мэргэжил дээшлүүлсэн, 19 оюутан богино хугацааны сургалтын дадлагад эрээн хотод хамрагдсан байна.

Онцлог зүйл:**Анхаарах асуудал:**

- Дотоодын оролцогч сонирхогч талуудын хамтын ажиллагааг албан ёсны болгох
- ЭЗБС-ийн Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа тогтмол бус, төгсөгчидтэй хамтран ажиллах байдал сул. Тухайлбал, төгсөгчдийн давтан сургалт

Дүгнэлт:

- Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай тэнхим, профессор багш нарын хамтран ажилладаг. Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч нэгжийн профессор багш нар, оюутнууд, төгсөгчдөөс хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээг тодорхой хэмжээнд үзүүлдэг. ХААИС-ийн хэмжээнд эдгээр үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилладаг. Буриадын ХАА-н академи, Өвөр монголын тариалангийн их сургууль, Шилийн гол аймгийн Ажил мэргэжлийн дээд сургууль, Европын холбооны зарим улсуудын их дээд сургуультай оюутан солилцож, дадлага хийлгэх, судалгаа хийх зэрэг ажлын эхлэл тавигдсан тухай хөтөлбөрийн удирдлага танилцуулсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Дотоодын сонирхогч талуудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг үзэглэх
- Хөтөлбөрийн нэгжээр хамтран ажиллах гэрээ, төслийн тоог нэмэгдүүлэх
- Төгсөгчдийн Холбооны үйл ажиллагааг тогтмол болгох, төгсөгчдийн давтан сургалтад анхаарч ажиллах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой эрх зүйн орчинг ХААИС-ийн санхүүгийн үйл ажиллагааны журам, 2015-5-5-ны А/140, ЭЗБС-ийн санхүүгийн журам, 2015-6-2-ны 47, ЭЗБС-ийн санхүүгийн дотоод журамд өөрчлөлт оруулах тухайл 2021-9-24-ны А/79 зохицуулсан.
- ХААИС-иас жил бүр бүрэлдэхүүн сургуулиудын төсвийг нэгтгэн гаргадаг ба 2023 оны төсвийн төсөлд ЭЗБС-ийн санхүүжилт туссан.

Онцлог зүйл:

- ЭЗБС нь ХААИС-ын орлогын 50 гаруй хувийг бүрдүүлдэг.
- Элсэгчдийн тоо бусад сургуулиас илүү бөгөөд орлого нь түүнээс хамаардаг.
- Магистр болон эчнээ сургалтын төлбөр нь 2023 оноос эхлэн салбар сургуулийн дэд дансанд төвлөрүүлж, захиран зарцуулах болсон.

Анхаарах асуудал:

- Санхүүгийн хувьд ХААИС-с хараат, бие даан хөгжих боломж хязгаарлагдмал

Дүгнэлт:

- ХААИС нь санхүүгийн нэгдсэн данс, бодлоготой. Бакалаврын сургалтын төлбөрийг 100% нэгдсэн дансанд төвлөрүүлдэг. Бүрэлдэхүүн сургуулийн хувьд шаардлагатай санхүүжилтээ ХААИС-д хүсэлт гарган авдаг. Санхүүжилтийн эх үүсвэрийн дийлэнх хувийг сургалтын төлбөр бүрдүүлдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- ХААИС нь хөтөлбөрийн санхүүжилтийн хэдэн хувийг багш, суралцагчийн хөгжилд зарцуулахыг тодорхой болгох, санхүүжилтийг сургууль, хөтөлбөрийн орц, гарцын үр дүнтэй уялдуулах, олон эх үүсвэртэй болгоход анхаарах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС нь мөргөтнийн идэвхжүүлэлтийн хөтөлбөри йг 2015-2017, Элсэлтийн идэвхжүүлэлтийн хөтөлбөрийг 2021 онд боловсруулж хэрэгжүүлж ажилласан.
- 2023-2024 онд хэрэгжүүлэх Элсэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ХААИС-ийн Сургалт цахим шилжилтийн бодлогын газраас 2023 онд боловсруулж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
- Хаврын улиралд элсэлтийн үйл ажиллагаанд зориулж сургууль, хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан тараах материалд тэмдэглэлийн болон хичээлийн дэвтэр, балыг шинээр хийж улам боловсронгуй болгон ажиллаж байна.

Онцлог зүйл:

- ХААИС-ийн элсэлтийн үеэр тараагддаг сурталчилгааны материал: *Тэмдэглэлийн дэвтэр* - ХААИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам, Бакалаврын хөтөлбөр, мэргэжлийн чиглэл, бүрэлдэхүүн сургуулиудад бэлтгэдэг мэргэжлийн хөтөлбөрүүдээр олгох ур чадвар, ажлын байр, мэргэжлийн эрэлт, хандлага, ЭЕШ өгөх хичээлийн тухай сурталчилгааны мэдээлэл агуулсан.
- *Тэмдэглэлийн дэвтэр* - ХААИС-ийн бүхий л мэдээллийг агуулсан QR код бүхий "Амьдралын ухааныг бид бүтээнэ" уриатай.
- *Хичээлийн дэвтэр* - ХААИС-ийн лого, эрхэм зорилго, сургуулийн түүхэн амжилтууд, сургалтын үйлчилгээ, гадаад хамтын ажиллагаа, оюутны үйлчилгээ, ХААИС-ийн сүлд дуу зэрэг мэдээлэл, сурталчилгааг агуулсан.
- *Бал* – утас байршуулах, гар утас болон компьютерийн дэлгэц дээр ажиллах точ, сургуулийн бүх мэдээллийг агуулсан QR код бүхий.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт тогтмол бус
- Маркетингийн санхүүжилтийн эх үүсвэр, төлөвлөлтөд анхаарах

Дүгнэлт:

- ХААИС нь мөргөтнийн идэвхжүүлэлтийн нэгдсэн бодлогоо тодорхойлсон. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт нэгдсэн журмаар явагддаг. Бүрэлдэхүүн сургуулийн хувьд маркетингийн санхүүжилтээ төв сургуулийн нэгдсэн төсвөөс авдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийг тогтмол хийж хэвших
- Маркетингийн санхүүжилтийг олон эх үүсвэртэй болох, төлөвлөлтөд анхаарах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС нь <https://elselt.muls.edu.mn>, <https://seb.muls.edu.mn>, <https://www.facebook.com/seb.muls.edu.mn/photos> хаягаар дамжуулан үйл ажиллагааны талаар мэдээллийг түгээдэг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж олон нийт, сонирхогч талуудад чиглэсэн үйл ажиллагааны талаар Санхүүгийн тэнхмийн 2018-2021 оны хичээлийн жилд гүйцэтгэсэн ажлын өөрийн үнэлгээний тайлангийн нэгтгэл болон Багшийн өөрийн үнэлгээний тайлан, 2018-2021-д дэлгэрэнгүй тусгасан.

Онцлог зүйл:

- Элсэгч, сонирхогч талуудад зориулсан тараах материал нь ХААИС, бүрэлдэхүүн сургуулийн элсэлт болон холбогдох сурталчилгааны мэдээллийг агуулсан тэмдэглэлийн дэвтэр, хичээлийн дэвтэр, бал нь өнгө үзэмж сайтай, мэдээлэл сайтай, хэрэглээ өндөртэй.

Анхаарах асуудал:

- Мэдээлэл түгээх сувгууд хязгаарлагдмал
- Мэдээлэл шинэчлэх үйл явцад хугацаа алддаг

Дүгнэлт:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд цаг үеийн мэдээллийг элсэгчдэд зориулсан тараах материал, гарын авлага, мэргэжлийн уралдаан, тэмцээн, олон нийтийн арга хэмжээгээр дамжуулан мөн сургууль, тэнхимийн веб болон фэйж хуудсаар түгээдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Мэдээлэл түгээх сувгуудын тоог нэмэгдүүлэх
- Мэдээллийн шинэчлэх явцыг цаг алдахгүй хийх

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС Монгол улсын "Дээд боловсролын тухай хууль" <https://legalinfo.mn/detail/251>, БСШУЯ-ны сайдын 2013 оны А/79, 2016 оны А/87, 2018 оны А/194 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", БСШУ-ны сайдын 2014 оны А/174 "Баклавырын

хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д үндэслэн 2016 онд А/153 “ХААИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх” журам, “ХААИС-д гадаад иргэнийг суралцуулах” журамаа боловсруулсан.

- Дээрх журамын дагуу элсэлт зохион байгуулдаг ба үр дүнг Элсэгчдийн ерөнхий шалгалтын босго дундаж оноо 2017-2022 он, Санхүү хөтөлбөрөөр элсэгчдийн тоо 2015-2022 он судалгаанд тусгасан байна.
- Мөн суралцагч сонгох, элсүүлэхээ Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, Оюутны гарын авлага 2017-2022 он хэвлэн гаргадаг.
- ЭЗБС-ийн <http://www.seb.muls.edu.mn>, Мэргэжлийн тэнхмийн багш нар <http://teacher.muls.edu.mn>, <http://student.muls.edu.mn>, <http://finance.muls.edu.mn/login.php> вэб хуудаст суралцагч сонгох, элсүүлэх мэдээллийг байршуулж сонгон шалгаруулдаг.

Онцлог зүйл:

- “Санхүү” хөтөлбөрөөр элсэгчдийн ЭЕШ-ын босго оноо нь БШУЯ, ХААИС болон ЭЗБС-ийн элсэгчдийн дундажаас өндөр

Анхаарах асуудал:

- Элсэгчдэд зориулсан мэдээлэлд ХААИС-ийн ЭЗБС-ийн “Санхүү” хөтөлбөр нь бусад их дээд сургуулийн ижил хөтөлбөрөөс ялгагдах онцлог тодорхой бус.

Дүгнэлт:

Элсэлтийн мэдээллийг олон сувгаар хүргэдэг. Мэргэжил сурталчлах өдөрлөг, ЭЕШ-ийн босго оноо өндөр элсэгчдийг урамшуулах (*сургалтын төлбөрийн хөнгөлт олгох, сургалтын төрийн сангийн зээл, тусламжид хамруулах*) ажлыг боломжит түвшинд хэрэгжүүлдэг. Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, “ХААИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх” журмын дагуу оюутан элсүүлэх ажлыг зохион байгуулж хэвшсэн байна. Элсэлтийг онлайнаар бүртгэн, мэргэжил сонголтыг зохион байгуулж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Элсэгчдэд зориулсан мэдээлэлд ХААИС-ийн ЭЗБС-ийн “Санхүү” хөтөлбөрийн бусад их дээд сургуулийн ижил хөтөлбөрөөс ялгарах онцлог тодорхой болгох

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- “Оюутны хөгжил хөтөлбөр”-тэй
- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан 2019-2022 он, “ХААИС-ийн хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанли” 2019-2022 он, ХААИС-ийн ЭЗБС-ийн жилийн ажлын тайлан, 2017-2022 он, “Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ. 2017-2022 он, Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээ 2017-2022 он, “Залуу санхүүч” клубын төлөвлөгөө, тайлан 2017-2022 он, “Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв”-ийн үйл ажиллагааны тайлан 2016-2022 он зэргээс зөвлөн туслах үйлчилгээний ажлын үр дүнг тайлагнасан.
-
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа 2017-2022 онуудад хийгдсэн
- Засгийн газраас суралцагчдад олгодог тэтгэлэг, амжиргааны зардалд хамрагддаг.,
- ХААИС-ийн захирлын нэрэмжит хуудасыг 2017-2022 онд оюутнуудад олгосон.

- МУ-ын ерөнхийлөгч, ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хамрагддаг.
- “Зориг сан”, М-СИ-Эс групп, Хаан банк “Шинэ оюутны тэтгэлэг” зэрэг оюутныг ивээн тэтгэх хөтөлбөр хэрэгждэг.
- ХААИС жил бүр “Шилдэг оюутан” шалгаруулж захирлын тушаал гарган баталгаажууладаг.. 2017-2022 он
- Оюутны ивээн тэтгэх хөтөлбөрүүдийг мэдээллийг ХААН банкны [00http://www.muls.edu.mn/](http://www.muls.edu.mn/), ЭЗБС-ийн <http://wwwseb.muls.edu.mn> вэб сайтуудад мэдээлдэг.

Онцлог зүйл:

- Оюутны сургалт, судалгаа, клубын үйл ажиллагааг тэнхим багш нар дэмжин ажилладаг.
- Жил бүр шилдэг оюутныг тэнхимээс шалгаруулан урамшуулдаг.
- Санхүүгийн мэргэжлийн байгууллага, холбоод, олон улсын байгууллагаас судлаач, мэргэжилтэнг урьж лекц уншуулах, сургалт дадлага зохион байгуулдаг.
- Санхүү хөтөлбөрөөр суралцагч оюутнуудад судалгаа шинжилгээний арга зүй эзэмшихэд нь албан, албан бус сургалтын хэлбэрийг ашиглан туслах ажлыг багш нарын ажлын төлөвлөгөөнд тусган ажилладаг.
- ЭЗБС, санхүүгийн тэнхим нь хамтран ажилладаг салбарын байгууллагууд төгсөгчидтэй холбоотой төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- “Санхүү” хөтөлбөрийн сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг жил бүр 50 хүртэлх байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэдэг гэсэн хэдий ч нотлох баримт дутуу.
“Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв”-ийн орон тоог цомхотгож, чиг үүргийг өөр ажилтны чиг үүрэг шилжүүлж байгаатай холбоотой энэ чиглэлийн ажил зогсонги байдалд орсон.

Дүгнэлт:

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр мэргэжлийн багш нар, Сургалтын албаны ажилтнууд, “Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв”, хамтран ажилладаг байгууллага, төгсөгчидтэй хийсэн уулзалтаар зөвлөх үйлчилгээг тогтмол өгч ирсэн. Харин сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр өгөх зөвлөх үйлчилгээ тогтмол бус, нотлох баримтгүй. Оюутнууд сургалтын албаны ажилтан, багш нарынхаа зөвлөмжид сэтгэл ханамжтай. Харин төгсөгч, ажил олгогчдын төлөөллөөс танхмийн сургалтын дасгал, кейсийг практиктай илүү уялдуулах шаардлагатайг илэрхийлсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оюутнууд хичээлээс гадуур хөгжих, чөлөөт цагийг тайтай өнгөрүүлэх, сургуулийн хэмжээний секц, дугуйлагын тоог нэмэгдүүлэх
- Оюутны холбооны үйл ажиллагаа тасралтгүй явуулах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС нь Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжих, хамтран ажиллах зорилгоор “Оюутны хөгжил хөтөлбөр”-ийг 2019 онд боловсруулж, Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал-ыг зохицуулсан баримт бичгийг гаргасан.
- Энэхүү ажлын үр дүнг Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ 2017-2022 он, “Job fair” өдөрлөгийн тайлан 2018-2019 он, Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл 2017-2022 он, Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн мэдээлэл 2017-2022 он, ХААИС-ийн ЭЗБС-ийн 2017-2022 оны жилийн ажлын тайланд тусгасан байна.

Онцлог зүйл:

- “Нийгмийн дадлагын хөтөлбөр” 2 кр сургалтын төлөвлөгөөнд нэмж оруулах болсон.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын болон урлаг, спортын уралдаан түүнийг зохион байгуулсан ажлыг үнэлж, урамшуулах тогтолцоо байхгүй.
- Оюутнууд хичээлээс гадуур хөгжих, чөлөөт цагаа таатай өнгөрүүлэх, сургуулийн хэмжээнд секц, дугуйланд хамрагдах боломж хязгаарлагдмал.
- Оюутны холбооны үйл ажиллагаа тогтмолжоогүй.

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн нэгж суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг. “Залуу санхүүч” клубын үйл ажиллагаа уламжлал болж ЭЗБС, тэнхмийн зүгээс сайн дэмжиж ажилладаг. Мэргэжлийн чиглэлийн улсын хэмжээний олимпиадад амжилттай оролцож иржээ. Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх нь тоон үзүүлэлттээс гадна зохион байгуулж буй ажлуудыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн төрөл, арга хэлбэр, хамрах хүрээ, манлайлал, өгөөжийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, хөтөлбөр зорилго, төгсөгчийн чадварын нэг тал гэж “харих” нь чухал.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын болон урлаг, спортын уралдаан түүнийг удирдан зохион байгуулсан багшийн ажлыг үнэлж, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх
- Сургуулийн хэмжээнд оюутнуудын хөгжих, чөлөөт цагаа таатай өнгөрүүлэх секц, дугуйлангын тоог нэмэгдүүлэх
- Оюутны холбооны бие даасан үйл ажиллагаа тогтмол болгох

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэх /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ асуудлыг 2016 онд боловсруулсан ХААИС-ийн бакалаврын сургалтын журмын “шилжилт хөдөлгөөн” заалт, Багц цагийн дүйцүүлэх журамд тус тус зохицуулсан. ХААИС-ийн <http://www.muls.edu.mn/>, ЭЗБС-ийн <http://wwwseb.muls.edu.mn> вэб хуудасаас харах боломжтой.
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний үр дүнг ХААИС, ЭЗБС-ийн захирлын 2017-2022 онд гаргасан “Суралцагчийн шилжилт хөдөлгөөн”-ий тушаал болон Шилжих хөдөлгөөнтэй холбоотой мэдээ, тайлан 2017-2022 он-д тусгасан.

Онцлог зүйл:

- Суралцагчийн шилжилт, хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг.

Дүгнэлт:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэж байна. Санхүү хөтөлбөрөөр суралцагч оюутнуудын хөдөлгөөн харьцангуй тогтвортой.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-ны сайдын 2012 оны 01 тушаалаар батлагдсан “Баклавр, магистр, докторын дипломын загвар”-ын дагуу боловсруулсан “ХААИС-ийн баклаврын сургалтын журам” 2016 он, “ХААИС-ийн төгсөлтийн үйл ажиллагааны журам, Төгсөлтийн баримт бичгийн загвараар төгсөлтийн баримт бичгийг бүрдүүлдэг. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл www.muls.edu.mn хуудаст туссан байна.
- Үр дүнг “Диплом энгэрийн тэмдэг олгох” ХААИС-ийн захирлын тушаал 2017-2022 оноос үзэх боломжтой.

Дүгнэлт:

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг зохих журмын дагуу тусгаж хэвшсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС нь “ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2019-2028” -д хөтөлбөрүүдийн нийтлэг зорилго, зорилтод нийцсэн багшийн бодлогоо тодорхойлсон байна.
- ХААИС-ийн “Хөдөлмөрийн дотоод журам” (2019 оны А/296), “ХААИС-ийн профессор багш ажиллуулах журам” (2017 оны А/86), “ХААИС-ийн багшийн мэргэжлийн ёс зүйн дүрэм ” (2008 оны А/66), “ХААИС-ийн профессор хөгжил чадамжийг үнэлэх журам” (2019 оны А/193) зэрэг эрх зүйн актуудад багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллыг зохицуулсан.
- Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлогын хэрэгжилтийг Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа 2017-2022 он, Мэргэжлийн суурь хичээл орсон багш нарын судалгаа 2017-2022 он, Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан, Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/, Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/-ны ажлуудад тусгажээ.

Онцлог зүйл:

- “Санхүү” хөтөлбөрийн хэрэгжүүлэгч нэгжийн 12 багш 100 хувь үндсэн орон тоогоор ажилладаг.
- Багш нарын 50% нь докторын зэрэгтэй.
- Багш нарын ажилласан дундаж хугацаа 12 жил

Анхаарах асуудал:

- Санхүү хөтөлбөрийн зорилгод нийцсэн санхүүгийн менежментийн олон чиглэлийн нарийн мэргэжлийн багш нар цөөн

Дүгнэлт:

Багш нар нь “Санхүү” хөтөлбөрийн тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол, дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн, эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, туршлагатай байх шаардлагад нийцэж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн багш нарын үндсэн мэргэжил нь нягтлан бодох бүртгэл, эдийн засагч байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Санхүү хөтөлбөрийн онцлогт нийцсэн санхүүгийн менежментийн нарийн мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцийг бүрдүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн асуудлыг “ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө” 2019-2028 он, “ЭЗБС-ийг 2011-2020 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө” 2011-2022 он, “Багшийн хөгжлийн хөтөлбөр” 2017 он гэсэн баримт бичигт тусгасан байна.
- 2017-2022 онд Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт, 2017-2022 онд Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгааг хийж баримтжуулсан байна.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхмийн багш нарын 58 хувь нь нягтлан бодогч, 1 багш санхүүгийн менежмент мэргэжилтэй.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн мэргэшүүлэх чиглэлд багшийн мэргэшсэн байдал, ур чадварыг үнэлж, урамшуулах тогтолцоогүй.
- Багшийн гадаад хэлний мэдлэгийн түвшинг ахиулах сургалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, дэмжих асуудал төлөвлөгөө төсөвт бүрэн тусаагүй.

Дүгнэлт:

- Багш нар гадаад, дотоодын төсөлд оролцож, хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургууль байгууллагын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ур чадвараа дээшлүүлэн хөгжиж байна. Багш нар үндсэн мэргэжил, боловсролын зэргийн чиглэлээс гадна мэргэжлээрээ тодорхой салбарт ажилласан туршлага, мэргэжил дээшлүүлсэн байдлын нэгдсэн судалгааг байхгүй байсан тул нэмж гаргуулав. Гадаад хэлний мэдлэг нь хэдийгээр хувь хүний асуудал боловч академик түвшинд хүрсэнээр хөтөлбөрийн төдийгүй судалгаа шинжилгээний ажлын чанарт ч нөлөөтэй. Багш нарын англи хэлний чадварыг дээшлүүлэх асуудлыг бодлогоор дэмжих, төлөвлөгөө, төсөвт тусгаж хэрэгжүүлэх ажил дутмаг байгаад дүгнэлт хийж гадаадын тодорхой байгууллагатай хамтран ажиллах хэлцлийн ажлыг эхлүүлээд байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

Багшийг хөтөлбөрийн чиглэлээр мэргэшүүлэх (хөрөнгийн үнэлгээчин, санхүүгийн шинжээч, хөрөнгийн зах зээлийн ... г.м)

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг “ХААИС-ийн профессор багш ажиллуулах журам” (2017 оны А/86), урамшуулах асуудлыг “ХААИС-ийн санхүүгийн үйл ажиллагааны журам” 2015 он, ХААИС, ЭЗБС-ийн захиралын тушаал, Эдийн засаг бизнесийн сургуулийн санхүүгийн дотоод журамд өөрчлөлт оруулах тухай, 2021-8-24, А/79 журмаар тус тус зохицуулсан.
- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентын тоон судалгаа 2017-2022 он, Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал 2017-2022 он, Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо 2017-2022 он зэрэг судалгаа нь багш бүр

эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийдэг, тэдний судалгааны үр дүнг тайлагнадаг болохыг харуулж байна.

Онцлог зүйл:

- Багш нар олон улсын IF-тэй сэтгүүлд 3 өгүүлэл хэвлүүлсэн
- Дотоод болон олон улсын төсөлд амжилттай оролцож байна.

Анхаарах асуудал:

- Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд хэрхэн нөлөө үзүүлж буйг хянадаг, хэмждэг эсэх тодорхой бус
- Нэг багшийн А цагийн ачаалал гүйцэтгэл өндөр (50-с дээш хувь), Б цагийн нормоос давсан цагийг тооцож үнэлдэггүй.

Дүгнэлт:

- Их сургууль нь санхүүгийн хувьд бие даасан, судалгаа, төслийн ажлын орлого зэрэг санхүүгийн бусад эх үүсвэрийг ашиглан менежементийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар профессор, багш нарын хөдөлмөрийг “бодитой үнэлэх” боломж бүрдсэн.
- Багш нар сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж байгаа ч “А” цагийн ачаалал өндөр. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын “Б” цагийн нормоос давсан кредитийг бүрэн тооцож үнэлэхэд асуудал байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн хөтөлбөрт ямар нөлөө үзүүлж буйг хянадаг, хэмждэг болох
- Санхүүгийн журмын 2.2.3 заалтын “Багшийн эрдэм шинжилгээний ажлын зардал” зүйлд тусган “ЭШ судалгааны ажлын “Б” цагийн нормоос давсан кредитийг бүрэн тооцож үнэлэх, нэг кредитийн үнэлгээг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, www.muls.edu.mn-ын дагуу хөтөлбөрийн багш нар жил бүр Багшийн өөрийн үнэлгээний тайлан 2017-2022 он гаргаж хөтөлбөрийн нэгж дээр тайлагнадаг ба Багшийн хавтас 2017-2022 он-т баримтжуулан хадгалдаг байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс Перегрин академийн үнэлгээний аргачилалаар 2017-2022 онд үнэлгээ хийж үр дүнгийн судалгааг гардаг.

Анхаарах асуудал:

- Удирдлагын нэгдсэн системийн хэрэгжилт эхлэлийн түвшинд байгаа
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ тайлан мэдээлэлд тусгах төдий байгаа

Дүгнэлт:

- Багшийн хөдөлмөрийн үнэлгээний үндэслэлийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Багшийн ажлын үр дүнгээр Шилдэг багш шалгаруулдаг. Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн үнэлгээг тогтмол хийдэг боловч үр дүнг тооцох, цаашид хэрэгжүүлэх ажил тодорхойгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Удирдлагын нэгдсэн системийг хэрэгжилтийн төгөлдөржүүлэх
- Багшийн үнэлгээний тайлангийн үр дүнг хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд бодитой тусган ажил хэрэг болгох

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт хийх, сайжруулах зорилгоор ЧДБ-ын журам, Хяналт шинжилгээ, үнэлгээний журам, ХААИС-ийн захиралын 2015-06-23-ны А/211 тоот тушаалын 1-р хавсралт, Дотоод аудитын журам, ХААИС-ийн захиралын 2015-06-23-ны А/211 тоот тушаалын 2-р хавсралтаар тус тус баталсан.
- Мөн ХААИС-ийн Чанарын асуудал хариуцсан нэгжийн түүхчилсэн замнал, Зураг 7-1, Хөтөлбөрийн ЧДБ-ыг хангах УЗБ-схем, Зураг 7-3, Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн чанарын тогтолцооны үйл явцын зураглал, Зураг 7-4 -с ХЧДБ болон түүний сайжруулалт хэрхэн хийгдэж ирсэнийг харах боломжтой юм.

Онцлог зүйл:

- ХААИС-ийн ЧДБ-ын бодлого түүнийг хэрэгжүүлэх журам, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж баталсан.
- Хөтөлбөрийн ЧДБ-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой олон схем, зураглалыг гаргасан.
- Чанарын алба хариуцсан нэгжийн үйл ажиллагааны хүрээ, Хөтөлбөрийн ЧДБ-ын стратегия тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- DMAIC-ын туршилтын үр дүн тодорхой бус
- ЧДБ-д хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо харьцангуй сул

Дүгнэлт:

ХААИС нь хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмыг бүрдүүлсэн байна. Энэ нь ЧДБ-ыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн, үйл явц эхэлсэн болохыг харуулж байна. Хөтөлбөрийн ЧДБ-ын стратегийг DMAIC зарчмаар тодорхойлсон, DMAIC-ийг туршилтыг эхлүүлсэн гэх боловч DMAIC-ын туршилт ямар шатанд явж байгаа,

түүний үр дүн тодорхой баримтаар нотлогдохгүй. ЧДБ-д хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцооны үр дүнг баталгаажуулах боломжгүй байлаа.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- DMAIC-ын туршилтыг эхлүүлэх, үр дүнг тодорхойлох аргачилалыг боловсруулах
- ЧДБ-д хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан байдлыг ХААИС, ЭЗБС, Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа 2017-2020 оны хичээлийн жил, 2020 (төгсөгч ажил олгогч), ХААИС, ЭЗБС-ийг 2019-2022 онд төгссөн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, 2017-2018, 2018-2019, 2019-2020 оны хичээлийн жилд хийсэн оюутны (төгссөн) сэтгэл ханамжийн үнэлгээнээс харах боломжтой.
- Түүнчлэн ХААИС-с 2019 онд Богино улиралын талаар оюутан, багш нараас авсан санал асуулгын судалгаа, 2017 онд багшийн сэтгэл ханамжийн судалгааг авсан байна.
- ХААИС болон ЭЗБС 2020-2021, 2021-2022 оны хичээлийн жилд оюутны сэтгэл ханамжийн үнэлгээг хийсэн ба 2021 онд ХААИС, СБЗА ба ЭЗБС, Санхүүгийн тэнхмийн багш нарын цахим хичээлд хөндлөнгийн үнэлгээ хийж ажлын хэсгийн тайлан (2020-2021 оны хичээлийн жилийн 4-р улирал) гаргасан нь хөтөлбөрөөр төгсөгчид сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж байгаа, төгсөгчдийн хөтөлбөрийн үр дүн дэх сэтгэл ханамж, мэргэжлээр олгосон цогц чадамжид дүгнэлт хийх боломжийг бүрдүүлж байгааг харуулсан юм.

Онцлог зүйл:

- ХААИС-с оролцогч, сонирхогч талуудаас судалгааг авдаг.
- Хөтөлбөрөөр төгсөгч нь хөтөлбөрийн үр дүнд сэтгэл ханамж сайтай.

Анхаарах асуудал:

- Төгсөгч, ажил олгогчдоос судалгааг тогтмол авдаггүй.
- Хөтөлбөрийн хэрэгжилт, сайжруулалтад оролцогч болон сонирхогч талуудын оролцоо харьцангуй сул

Дүгнэлт:

- ХААИС Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байгаа эсэхийг төрөл бүрийн судалгааг тасралтгүй авч үр дүнгийн тайланг бичиж ирсэн. Багш нар, оюутан болон төгсөгч, ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгааг авдаг боловч тогтмол бус. Төгсөгч, ажил олгогч талуудтай хийсэн ярилцлагаар төгсөгчдийн өөрийгөө илэрхийлэх ярих ур чадвар, компьютерийн хэрэглээний програм дээр ажиллах

чадвар, гадаад хэлний түвшинг сайжруулах шаардлагатай гэсэн саналууд нийтлэг гарсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Багш, оюутан болон төгсөгч, ажил олгогчоос авах сэтгэл ханамжийн судалгааг тогтмол болгох, саналыг хөтөлбөрийн хэрэгжилтэд тусгаж хэвших, үр дүнг мэдээлэх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ЭЗБС нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн үнэлгээний Перегрин академийн үнэлгээг 2017-2021 онд хийлгэсэн ба үр дүнгийн судалгааг хийдэг.
- Дотоодын “Перегрин” байгууллагаар хөндлөнгийн үнэлгээг хөтөрбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс 2016-2018 онд хийсэн.
- ХААИС, СБЗА ба ЭЗБС, Санхүүгийн тэнхмийн багш нарын цахим хичээлд хөндлөнгийн үнэлгээ хийж, ажлын хэсэг тайлан (2020-2021 оны хичээлийн жилийн 4-р улирал) гаргасан.

Онцлог зүйл:

- Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хийдэг “Перегрин” академийн аргачилал дахь СРС хичээлүүдээр 2-р курсын оюутнуудаас 2016-2018 онд шалгалт авч хичээлүүдийн дундаж үзүүлэлтээр үр дүнг гаргаж Мэргэжил сонголт хийх үндэслэл болгож ашигласан.

Дүгнэлт:

- Дотоодын БМИҮЗ-өөр хөтөлбөрөө анх удаа магадлуулж байгаа. 2024 онд ОУМИ-д орохоор төлөвлөсөн. Сургалтын чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн үнэлгээний Перегрин академийн шалгалтад ЭЗБС-ийн хөтөлбөрүүд (санхүүгээс бусад) ордог. Шалгалтын СРС хичээлд Санхүү хөтөлбөрийн 1-2 хичээл болон энэ мэргэжлийн оюутнууд дүгнэгддэг. Хөндлөнгийн үнэлгээг дотоодын хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар хийлгэсэн баримт байхгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөндлөнгийн үнэлгээг дотоодын мэргэжлийн байгууллагаар хийлгэх боломжийг судлах, хэрэгжүүлэх

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгч лэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2	1.2		Хөтөлбөрийн зорилгыг үндэсний мэргэшлийн хүрээ, холбогдох мэргэжлийн салбар, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлээгүй
2	Сургалтын үйл ажиллагаа	2	2.1		Сургалтын төлөвлөгөөнд хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага тодорхой бус. Хөтөлбөрийн мод дахь цөм хичээлүүд тодорхой бус.
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	3.2		Оролцогч, сонхогч талуудаас хөтөлбөрт зайлшгүй шаардлагатай ур чадварыг нэмэгдүүлэх агуулга, програм хангамж, санхүүжилт тодохой бус, төсөв, төлөвлөгөөнд тусгаагүй.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Багшийн үйл ажиллагаа	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
	Нийт	23	3		
Дүгнэлт		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ХААИС, ЭЗБС
Хөтөлбөрийн нэр	Санхүү
Хөтөлбөрийн индекс	D041201
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Харьцуулсан сургалтын төлөвлөгөөг /гадаад дотоодын их сургууль/ сургалтын кредитээр, мэргэжил/мэргэшүүлэх, заавал/сонгон судлах хичээлээр давуу болон сул тал, ялгаатай, онцлог талуудыг харгалзан дүгнэх. - Төгсөгчийн загварыг сайжруулах. - Оролцогч сонирхогч талуудын санал зөвлөмжид тулгуурлан хөтөлбөрийг тогтмол сайжруулах.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд, хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг сайжруулах - Сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагын удирдамжид мэргэшүүлж агуулгыг нарийвчилж илүү сайжруулах - Сургалтын төлөвлөгөөнд сонгон судлах хичээлийг нэмэгдүүлэх - Сургалтын төлөвлөгөөндөө шинжилгээ хийж дүгнэх - Хөтөлбөрийн хичээлүүдийг илүү төрөлжүүлэх - Ямар шалгуур хангасан оюутан Төгсөлтийн ажил бичих, улсын шалгалт өгөхийг тодорхой болгох - Сургалтын шинэ технологи турших, нэвтрүүлэх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> - Лаборатори болон лекцийн нэг суудалд ногдох талбайг стандартын түвшинд хүргэх - Сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх зардлын ХААИС-ийн төсөвт суулган шийдвэрлүүлэх - Номын сангаар үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх. - Номын сангийн шинэчлэл өөрчлөлт, орчны талаар мэдээллийг оролцогч сонирхогч талуудад мэдээлэх, үйл ажиллагааг тогтмол болгох
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Эрхзүйн баримт бичиг, Тайлан төлөвлөгөөний хэрэгжилт, Сургалтын УМС-ийн ашиглалт, хяналт, ил тод байдалд дүн шинжилгээг тогтмол хийж үр дүнг тайланд бүрэн тусгадаг болох - Хөтөлбөрийн шинэчлэл, эрэлт хэрэгцээг тодорхойлоход оролцогч сонирхогч талуудадын оролцоог илүү тодорхой болгох, эргэх холбоог сайжруулах - Санхүүгийн тэнхим хамтын ажиллагааны гэрээг нэмэгдүүлэх - Төгсөгчдийн Холбооны үйл ажиллагааг тогтмол болгох, төгсөгчдийн давтан сургалтад анхаарах - Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаанд гишүүдийн үүрэг оролцоог бодитой болгох - Санхүүжилтийн багш, суралцагчийн хөгжилд зарцуулах хэмжээг тодорхой, олон эх үүсвэртэй болгох - Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийг тогтмол хийж хэвших, санхүүжилтийн олон эх үүсвэрт анхаарах

	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл түгээх сувгуудын тоог нэмэгдүүлэх, мэдээллийн шинэчлэлийг цаг алдахгүй хийх
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн хэмжээнд оюутнууд хичээлээс гадуур хөгжих, чөлөөт цагаа өнгөрүүлэх, секц, дугуйланд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх - Оюутны холбооны үйл ажиллагаа сайжруулах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн хөрвөх чиглэлээр багшийг мэргэшүүлэх - Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн хөтөлбөрт ямар нөлөө үзүүлж буйг хянадаг, хэмждэг болох - “Б” цагийн нормоос давсан кредитийг бүрэн тооцож үнэлэх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - DMAIC-ын туршилт түүний үр дүнг тодорхойлох аргачилалыг боловсруулах - ЧДБ-д хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх - Оролцогч, сонирхогч талуудаас авах сэтгэл ханамжийн судалгааг тогтмол болгох, саналыг хөтөлбөрийн хэрэгжилтэд тусгаж хэвших. - Хөндлөнгийн үнэлгээг дотоодын мэргэжлийн байгууллагаар хийлгэх боломжийг судлах, хэрэгжүүлэх
ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
1.2	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн зорилгыг холбогдох мэргэжлийн салбар, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлээгүй
2.1	<ul style="list-style-type: none"> - Сургалтын төлөвлөгөөнд хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага тодорхой бус.
3.2	<ul style="list-style-type: none"> - Оролцогч, сонирхогч талуудаас хөтөлбөрт зайлшгүй шаардлагатай ур чадварыг нэмэгдүүлэх агуулга, програм хангамж, санхүүжилт тодохой бус, төсөв, төлөвлөгөөнд тусгааагүй

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ХААИС, ЭЗБСургуулийн “Санхүү” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнесийн удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Б.ЭНХТУЯА

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Г.БИЛГЭЭ

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Л.ГҮНЖАРГАЛ

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

ХААИС-ЭЗБС-ийн Санхүүгийн тэнхимийн Санхүү хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хүрээнд хийгдэх оролцогч талуудын уулзалтын нэрс

Хүснэгт №1 Багш нарын төлөөлөл

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Гарын үсэг
1	Д.Далхжав	Зөвлөх профессор	Даатгалын онол арга зүй	99050845	
2	П.Уранчимэг	Дэд проф	Санхүүгийн үндэс	99187473	
3	О.Балжин	Багш	Зээлийн удирдлага	88026473	
4	А.Энхтуяа	Ахлах багш	Төрийн санхүү	99166115	
5	Ш.Эрдэнэбилэг	Багш	Мөнгөний бодлого	99098785	
6	З.Ядмаа	Дэд проф	ОУ санхүү	99748787	
7	Х.Бумдэлгэр	Ахлах багш	Эрсдлийн удирдлага	91218501	
8	П.Буяннэмэх	Ахлах багш	Санхүү менежмент	80819365	
9	Г. Бадамцэцэг	Дагалдан багш	Санхүүгийн эрх зүй	90994599	
10	Д.Шинэбаяр	Ахлах багш	ЭЗ-ийн шугаман загвар	98099499	
11	Г.Буманжаргал	Ахлах багш	Статистик	99134981	
12	Ц.Цэрэндаваа	Багш	ЭЗ-ийн онол	99373010	

Хүснэгт №2 Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог, нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Д.Баяраа	ТЕГ, Ахлах мэргэжилтэн, Гавъяат эдийн засагч	89635599	<u>Цахим уулзалт</u>
2	Б.Батжаргал	Таван богд ХХК, Ерөнхий нягтлан бодогч	99051057	<u>Цахим уулзалт</u>
3	Ч.Болор-Эрдэнэ	ЧД, Татварын хэлтэс, Хяналт шалгалтын татварын улсын байцаагч	99107217	<u>Цахим уулзалт</u>
4	С.Лхагвадорж	НДЕГ, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын орлогч дарга	99110716	<u>Цахим уулзалт</u>
5	Д.Алтан-Очир	МТ групп, Гүйцэтгэх захирал	98101010	<u>Цахим уулзалт</u>
6	Б.Алтангэрэл	ТОП моторс, Санхүү эрхэлсэн захирал	88882567	<u>Цахим уулзалт</u>
7	Д.Оюу	Голомт банк, ХНГазар, Үйл ажиллагааны хэлтсийн захирал	99083051	<u>Цахим уулзалт</u>
8	О.Бат-Эрдэнэ	МУ, Сангийн яам. Нягтлан бодогч	99994095	<u>Цахим уулзалт</u>
9	Ү.Гончигболд	National Life даатгал, Хөрөнгө оруулалтын шинжээч	99042514	<u>Цахим уулзалт</u>
10	Э.Догмидмаа	Кэмп партнер ХХК, Санхүүгийн менежер	80913051	<u>Цахим уулзалт</u>

Хүснэгт №3 Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Б.Сайнсанаа	2018 он	ХХБанкны төв, Хяналт, шалгалтын мэргэжилтэн	95951099	<u>Цахим уулзалт</u>
2	С.Бадамцэцэг	2018 он	Бид ББСБ, Хөрөнгө оруулалтын менежер	99266902	<u>Цахим уулзалт</u>
3	Булганням	2018 он	Голомт банк, Зээлийн эрсдлийн шинжээч	99212121	<u>Цахим уулзалт</u>
4	Ү.Гончигболд	2019 он	National Life даатгал, Хөрөнгө оруулалтын шинжээч	99042514	<u>Цахим уулзалт</u>
5	О.Бат-Эрдэнэ	2019 он	Сангийн яам, Нягтлан бодогч	99994095	<u>Цахим уулзалт</u>
6	Т.Лхагвадорж	2019 он	ХААН банк, Зээлийн судалгааны мэргэжилтэн	99025341	<u>Цахим уулзалт</u>
7	Т.Очир	2020 он	Голомт банк, Арилжааны менежер	99357535	<u>Цахим уулзалт</u>
8	Э.Догмидмаа	2020 он	Кэмп партнер ХХК, Санхүүгийн менежер	80913051	<u>Цахим уулзалт</u>
9	А.Сүхбат	2020 он	Нэт капитал ББСБ, Зээлийн ахлах менежер	98823377	<u>Цахим уулзалт</u>
10	Х.Алтаннаран	2021 он	Бичил глобус ББСБ, Зээлийн эдийн засагч	88100343	<u>Цахим уулзалт</u>
11	Б.Очирдарь	2021 он	Грийн групп, Эдийн засагч	99180997	<u>Цахим уулзалт</u>
12	Б.Очирлхагва	2021 он	Инвекор ББСБ, Зээлийн эдийн засагч	80001922	<u>Цахим уулзалт</u>
13	Г.Оюундарь	2022 он	Хөх Үүр Тур ХХК, Нягтлан бодогч	80440614	<u>Цахим уулзалт</u>
14	Э.Гантуяа	2022 он	ШСБХТ, Ногоон бүтээмжтэй хөгжлийн бодлогын газрын мэргэжилтэн	85774703	<u>Цахим уулзалт</u>
15	Н.Дашжанлав	2022 он	Голомт банк зээлийн газар, Зээлийн мэргэжилтэн	99229619	<u>Цахим уулзалт</u>

Д/Д	Овог. Нэр	Оюутны код	Сонгосон байдал	Курс	Утас	Гарын үсэг
1	Н.Мөнгөнчимэг	5718012	Дотуур байранд амьдагдаг	4	91292291	
2	Ж.Мөнхзаяа	5719001	Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог	4	94492737	
3	Ц.Авирмэд	5719013	Дотуур байранд амьдагдаг	4	88326472	
4	Ш.Энхзул	5720013	Хөдөө орон нутгаас	3	94900921	
5	Н.Азжаргал	5720015	Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог	3	95774977	
6	Э.Баярмаа	5720019	Хөдөө орон нутгаас	3	95670421	
7	Б.Сувд	5720020	Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог	3	91199173	
8	П.Мичидмаа	5720026	Хөдөө орон нутгаас	3	99911198	
9	Б. Сүхбат	5720036	Хөдөө орон нутгаас	3	85517399	
10	М.Юмсүрэн	5720039	Хөдөө орон нутгаас	3	80317334	
11	М.Солонго	5720072	Улаанбаатараас	3	88086017	
12	М.Тэмүүжин	5720076	Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог	3	88229062	
13	Б.Очирсүрэн	5720082	Хөдөө орон нутгаас	3	93434358	
14	Сүрлэг (гадаад)	5720087	Дотуур байранд амьдагдаг	3	80515030	
15	Ү Жэнжэн (гадаад)	5720088	Дотуур байранд амьдагдаг	3	95852190	
16	Тан Хо Нан (гадаад)	5720089	Дотуур байранд амьдагдаг	3	80373074	
17	ЛинШуе (гадаад)	5720090	Дотуур байранд амьдагдаг	3	95800766	
18	Г.Ганцацрал	5721100	Улаанбаатараас	2	94623854	
19	А.Бямбадорж	5721101	Улаанбаатараас	2	99646341	
20	С.Саруул	5721103	Хөдөө орон нутгаас	2	80450884	
21	А.Золжаргал	5721104	Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог	2	99236886	
22	А.Болормаа	5721106	Улаанбаатараас	2	95755713	
23	Б.Эгшиглэнзаяа	5721116	Хөдөө орон нутгаас	2	88298662	
24	Б.Ариунзул	5721138	Хөдөө орон нутгаас	2	94787139	
25	Д.Гантулга	5721141	Улаанбаатараас	2	88481235	
26	Ж.Улсболд	5721146	Улаанбаатараас	2	95739590	
27	Ш.Анужин	5721149	Улаанбаатараас	2	86866323	
28	Э.Азжаргал	5721150	Улаанбаатараас	2	89199283	
29	Н.Бат-Эрдэнэ	5721151	Улаанбаатараас	2	86967679	
30	Б.Хуяг-Эрдэнэ	5721152	Шилжиж ирсэн	2	94140527	

31	Б.Мөнх-Оргил	5721153	Шилжиж ирсэн	2		
32	М.Марал	5722009	Дотуур байранд амьдагдаг	1	90191675	
33	Ж.Баярчимэг	5722012	Улаанбаатараас	1	99314815	
34	Б.Билгүүн	5722013	Улаанбаатараас	1	85177050	
35	Х.Цэнд-Аюуш	5722017	Дотуур байранд амьдагдаг, Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог	1	86552018	
36	Э.Саруул-Эрдэнэ	5722020	Улаанбаатараас	1	91884181	
37	Ц.Балжмаа	5722021	Улаанбаатараас	1	99935995	
38	Б.Мөнх-Эрдэнэ	5722025	Хөдөө орон нутгаас	1	94779150	
39	Ш.Үйлстөгөлдөр	5722028	Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог	1	90953232	



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ
ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН
СУРГУУЛЬ

17029 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
22 дугаар хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 252, 253
И-мэйл: info_seb@muhs.edu.mn
Вэб сайт: www.muhs.edu.mn

2023.06.07 № 01/234
танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ-Л

Шинжээчийн тайланд
санал хүргүүлэх тухай

ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн хэрэгжүүлж буй D041201 индекстэй “Санхүү” хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажилд хамтран ажиллаж байгаа та бүхэнд талархаж буйгаа илэрхийлье.

Бид “Санхүү” мэргэжлийн хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийсэн шинжээчийн багаас 2023 оны 06 сарын 06-д ирүүлсэн тайлантай танилцаж магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний багийн зүгээс санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Жич: Саналыг хавсаргав.

ЗАХИРАЛ  Т.ЭРДЭНЭЧУЛУУН



V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

ХААИС-ийн ЭДИЙН ЗАСАГ БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН САНХҮҮ БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР (041201)-ӨӨС ИРҮҮЛСЭН АЛБАН БИЧГИЙН ХАРИУ

ШИНЖЭЭЧ Л.ГҮНЖАРГАЛ (Ph.D)

		ХААИС-с ирсэн санал	ШИНЖЭЭЧИЙН ХАРИУЛТ
Шалгуур 1.2	<p>Зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн зорилгыг холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхэд анхаарах. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн зорилгыг холбогдох мэргэжлийн салбар, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулах 	<ul style="list-style-type: none"> • БШУЯ- болон ХААИС-аас гаргасан нийтлэг, эрх зүйн зохицуулалтын хүрээнд, нийгмийн хэрэгцээ шаардлага, оролцогч талуудын болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөтөлбөрийг сайжруулан хөтөлөрийн мэргэжлийн дэд хороо, ерөнхий хороогоор хэлэлцүүлдэг. ХААИС-н захирлын 2014 оны А/228 дугаар тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн хорооны журам”-д зааснаар 3 хөтөлбөрийн хороонд төгсөгч, ажил олгогчдын төлөөллийг оролцуулж хөтөлбөрийн зорилго, зорилгоо хэлэлцүүлж тодорхойлдог бөгөөд “Санхүү” хөтөлбөрийн төлөвлөлтийг хийх үед дээрх албан ёсны үйл явцаар хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, төгсөгчдөд 	<ul style="list-style-type: none"> • Илрэл нотолгоог хангалттай үзүүлээгүй, нотолж чадаагүй. “Санхүү” хөтөлбөрийн зорилгын өөрчлөлт, биелэлттэй хамааралтай асуудлыг тэнхимийн хурлын протоколд дурдсан байсан. • Мэргэжлийн салбар оролцогч талуудыг хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон, түүнд нийцүүлсэн оролцогч тал, зах зээлийн судалгааны үр дүнг үзүүлж харуулж чадаагүй. • “Санхүү” хөтөлбөрийн хорооны гишүүнд 2019 оны төгсөгч О.Бат-Эрдэнэ (төгсөгчийн төлөөлөл), 2019 оны төгсөгч Ү.Гончигболд (ажил олгогчийн төлөөлөл) болон тэнхимийн багш нараас бүрдсэн байсан. • 1-р шалгууртай холбоотой илрэл нотолгоог тухайн тэнхимийн зүгээс хангалттай үзүүлж нотолж чадаагүй.

		олгох мэдлэг чадвар, хандлагыг тодорхойлж батлуулсан.	
Шалгуур 2.1	<p>Анхаарах асуудал:</p> <ul style="list-style-type: none"> - Санхүүгийн тэнхимд дадлага хийхтэй холбоотой байгууллагуудын гэрээ, санамж бичиг одоогоор байхгүй. - Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварыг сургалтын төлөвлөгөөн дэх нэгж хичээлээр олгох байдал хязгаарлагдмал. Жишээлбэл “Санхүүгийн менежмент I” хичээл 3.2.1 “Бизнесийн орчинд үнэлэлт өгөх удирдан зохион байгуулахтай холбоотойгоор эрэлт, борлуулалт үнийг таамаглах” гэсэн мэргэшүүлэх ур чадварыг л олгож байна. Тус хичээл бусад өөр хамааралтай мэдлэг, чадвар өгөхгүй байхаар хуваарилсан. “Хувь хүний санхүү” хичээл тухайн хөтөлбөрт ямар ч мэдлэг, чадвар, хандлага олгогдохоор тавигдаагүй байна. 	<ul style="list-style-type: none"> • ЭЗБС-ийн мэргэжлийн тэнхимүүд оюутан дадлагажуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээг сургууль ба байгууллагын түвшинд хийдэг. ХААН банкттай хийсэн оюутан дадлагажуулах гэрээ нь 2021 онд хугацаа дууссан бол 2022-2023 оны хичээлийн жилд ХХБ, Голомжт банкуудад оюутан дадлагажуулах, интерншип хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр гэрээ байгуулсан байгаа. • “Санхүү” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заасны дагуу оюутан суралцах хугацаандаа 127 кредит цагийн хичээлийг судлах бөгөөд үүнд боловсролын суурь хичээл 27%, мэргэжлийн суурь хичээл 26%, мэргэшүүлэх хичээл 47% -ийн жинг тус тус эзэлж байна. Хичээлийн эдгээр гурван бүлэг тус бүр оюутанд суурь эрдмийн, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх ур чадваруудыг олгохоос гадна хичээл бүр хувь хүний хандлага, ур чадварыг хөгжүүлэхэд давхар чиглэсэн байхаар төлөвлөж боловсруулсан. Мөн тухайн үед /2015-2018/ хөтөлбөрийн зорилго, зорилт, мэдлэг ур чадварын 	<ul style="list-style-type: none"> • Шинжээчээр ажиллах хугацаанд оюутан дадлага хийхтэй холбоотой албан ёсны хийсэн гэрээ байхгүй гэдгийг тэнхим өөрөө хэлж нотолсон. • “Санхүү” бакалаврын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан, “Санхүү” бакалаврын сургалтын хөтөлбөрт МЭДЛЭГ, ЧАДВАР-ыг тодорхойлсон. Дээрх 2 баримт бичигт ХАДЛАГА огт дурдагдаагүй хирнээ багшийн нэгж хичээлийн хөтөлбөрт мэдлэг, чадвар, хандлага гэж задарч орсон. Сайн кэйсээр шалгарч бусад их дээд сургуулиудад танилцуулга хийсэн тухай баримт мэдээллийг тэнхимээс огт илрэл нотолгоо гэж үзүүлээгүй огт дурдаагүй. • Гол цөм хичээлийг тодорхойлсон байдал хангалтгүй.

	<p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүд нь хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг хэрхэн олгох байдлыг дахин сайжруулах. 	<p>уялдааг хангаж сургалтын хөтөлбөрөө боловсруулсан сургуулийн кэйсээр шалгарч бусад их дээд сургуулиудад танилцуулга хийж байсан.</p> <ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрөөр олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг сургалтын төлөвлөөн дэх нэгж хичээлээр олгох байдалд матриц төлөвлөлтийг хэвлэж бэлтгэхэд дутагдуулж орхигдуулсан талтай. Гэвч хичээл бүрийн стандарт хөтөлбөрт оюутанд олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг дэлгэрэнгүй тодорхойлж өгсөн нь Санхүү хөтөлбөрөөр төгсөгчид олгох мэдлэг, ур ч адва, төгсөгчийн загвартай нягт уялдах юм. 	
<p>Шалгуур 2.1 Шалгуур 2.2</p>	<p>Зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> - Сургалтын төлөвлөгөөнд сонгон судлах хичээлийг нэмэгдүүлэх. - Сургалтын төлөвлөгөөндөө шинжилгээ хийж дүгнэх. - Хөтөлбөрийн хичээлүүдийг илүү төрөлжүүлэх. - Сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагын удирдамжид мэргэшүүлж агуулгыг найрийвчилж илүү сайжруулах 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн үнлгээний багаас эдгээр зөвлөмжтэй санал нийлж байна. 	

Л.Гүнжаргал:

- ❖ Шинжээч миний бие тус сургуулийн ирсэн мэдээлэлтэй бүрэн танилцав. Шинжээч 1.2, 2.1, 2.2-т **зөвлөсөн, анхааруулсан, шаардлага** зэрэгт тусгасан зүйлсийг шинжээч сургууль дээр ажиллах хугацаанд нотлож чадаагүй, баримт байгаагүй, түүнээс хойш гэрээ байгуулж, албажуулсан байх талтай. Гэхдээ хариуцсан тэнхимээс холбогдох илрэл, баримт нотолгоог (зургаар, мэйлээр) илгээвэл тайланд дахин засвар оруулах бүрэн боломжтой болно. **Жишээлбэл дадлагын гэрээ, хөтөлбөрийн зорилгыг оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн байхаар тодорхойлсон судалгааны үр дүн гэх мэт.**

ШИНЖЭЭЧ Г.БИЛГЭЭ (Ph.D)

		ХААИС-с ирсэн санал	ШИНЖЭЭЧИЙН ХАРИУЛТ
Шалгуур 3.2 Сургалтын хэрэглэгдэхүүн	<p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> – Ажил олгогч, төгсөгч, оюутан, багш нарын судалгааны үр дүнг харгалзан хөтөлбөрт зайлшгүй шаардлагатай ур чадвар олгох сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөц түүний санхүүжилтийг төсөв, төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Өөрийн үнлгээний багаас Шаардлагатай санал нэг байгаагаа илэрхийлсэн байна. 	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөр дээр ажиллах хугацаанд ХААИС-с албан бичгээр ирүүлсэн тайлбар дахь мэдээлэлтэй танилцсан. Шаардлагад дурьдсан зүйлс хөтөлбөр болон санхүүгийн төсөвт ерөнхий, бөөн дүнгээр тусгасан байсан тул нотлогдоогүй. Цаашид шийдвэрлэх, тулгамдсан асуудал гэдгийг ярьж байсан тул энэ дүгнэлтийг хийсэн болно..

2023-06-12